# СЭЛЭНГЭ АЙМГИЙН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
## /Жилийн эцсийн байдлаар/

| № | | Арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар) | Хэрэг жилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Он | Түвшин | | | |
| **НЭГ. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ** | | | | | | | | | |
| **Зорилго. Үндэсний эх хэл, соёл, түүх, уламжлалаа дээдлэн байгальтай зөв харилцах чадварт суурилж, эх орноо хайрлах нэгдмэл үзэл санаатай монгол хүнийг соён гэгээрүүлнэ.** | | | | | | | | | |
| **Үндэсний бахархал, эв нэгдэл** | | | | | | | | | |
| 1 | 1 | "Монгол, төгсөшгүй, мөхөшгүй, мохошгүй" язгуур урлагийн хамтлагуудын нэгдсэн тоглолтыг зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Үзэгчдийн тоо | 2021 | "Covid-19" цар тахлын улмаас тоглолт зохион байгуулагдаагүй. | Язгуур урлагийн хамтлагуудын тоглолтыг зохион байгуулсан байна. | “Монгол төгсөшгүй, мөхөшгүй, мохошгүй” язгуур урлагийн нэгдсэн тоглолтыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Монгол угсаатан ястны хувцасны үзүүлэх тоглолт, уртын дуу, морин хуур, хөөмий, бий биелгээний сургалт, уран нугаралт, Монгол цам, тоглоом наадгайн танин мэдэхүйн боловсрол олгох “Өв Соёл” арга хэмжээнүүдийг зохион байгуулж язгуур урлагийн нэгдсэн тоглолтыг “Өв-соёлын өргөө”-нд зохион байгуулж 600 гаруй иргэн, хүүхэд залуучуудад толилууллаа. | 90% |
| **1.2 Нүүдлийн соёл иргэншилт монгол** | | | | | | | | | |
| **Зорилт.Нүүдлийн өв, соёлоо хамгаалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ.** | | | | | | | | | |
| 2 | 1 | "Монгол гэр"-ийн холбоотой ардын мэдлэгийг сургууль, цэцэрлэгээр | Орон нутгийн төсөв | Монгол гэрээр хангагдсан сургууль, цэцэрлэгийн тоо Мэдлэг | 2021 | Монгол гэрээр хангагдсан 9 сургууль, 15 цэцэрлэг | Монгол гэр барих, буулгах аргад суралцсан сурагчдын эзлэх 10 хувь, | Нийт суралцагчдын 20 хувь монгол гэр барих, буулгах аргад суралцаад байна. 19 цэцэрлэг, 9 сургууль ёс заншлын гэр өргөөтэй болсон бөгөөд Сүхбаатар сумын 8 цэцэрлэгийн 300 гаруй хүүхдэд | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дамжуулан, хүүхэд бүрт өвлүүлэх | | олгох арга хэмжээний тоо Монгол гэр барих, буулгах аргад суралцсан сурагчдын эзлэх хувь | | | Монгол гэрээр 15 сургууль, | сургалт, хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан бол Сүхбаатар сумын 4, Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгүүд орон нутгийн төсвийн 27.5 сая төгрөгийн хөрөнгөөр шинээр “Гэр өргөө”-г ашиглалтад оруулж, нүүдэлчин өв соёлоо хадгалж, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх сургалт, үйл ажиллагааг явуулах боломжтой болсон. | |
| 3 | 2 | Насан туршийн боловсролын төв, нэгжийг түшиглэн байгууллага, хамт олон, иргэдэд зориулсан монгол бичгийн сургалтыг зохион байгуулах, үр дүнг тооцох | Улс, Орон нутгийн төсөв | Үндэсний бичиг үсэг сурсан хамт олон, иргэдийн тоо | 2021 | Байгууллага, хамт олон, иргэдэд зориулсан монгол бичгийн сургалтыг зохион байгуулсан сургалтын тоо 70 Үндэсний бичгээр уншиж, бичиж чаддаг болон төрийн албан хаагч, иргэдийн тоо 2000, эзлэх хувь 34.6 хувь | Үндэсний бичиг үсэг сурсан төрийн албан хаагч иргэдийн эзлэх хувийг 10 хувиар нэмэгдүүлсэн байна | Насан туршийн боловсролын төв, нэгжүүд, ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл бичиг, уран зохиолын багш нар байгууллагын хүсэлтийн дагуу төрийн албан хаагч, иргэдэд үндэсний бичгийн хичээлийг 3 түвшинд хуваан, 16 удаагийн сургалт, уралдаан тэмцээнийг 22 удаа зохион байгуулж, үндэсний бичгийн түвшин ахиулах сургалтад 336 иргэн хамруулж, унших, бичих чадварыг нэмэгдүүлснээр үндэсний бичиг үсэг сурсан төрийн албан хаагч, иргэдийн эзлэх хувийг 40.6 хувь буюу өнгөрсөн жилийнхээс 5.8 хувиар нэмэгдүүлсэн. | 60% |
| 4 | 3 | Аймаг, сумын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хамгаалуулах | Улсын төсөв | Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалсан хувь | 2021 | Аймгийн 3238 түүх соёлын үл хөдлөх дурсгалт газар тоологдсон | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын 40 хувийг иргэн, хуулийн этгээдээр хамгаалуулсан байна | Аймаг, сумын ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн хэмжээнд 1963 гэрээт харуулуудтай гурвалсан гэрээг шинэчлэн байгуулж, үүрэг хариуцлага, хараа хяналтыг нэмэгдүүлэх талаар чиглэл өгч, санал санаачлагыг дэмжин ажилласан. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын 63 хувийг иргэн, хуулийн этгээдээр хамгаалуулснаар дурсгалын хадгалалт хамгаалалтад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн хяналтыг сайжрууллаа. Аймгийн хэмжээнд нийт 3237 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрыг тоолж, улсын “RICH-4” программд шивж оруулснаар статистик мэдээллийг баяжуулах, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдлыг улсын болон орон | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нутгийн хэмжээнд нэгтгэх боломжийг бүрдүүллээ. | |
| 5 | 4 | Баримтат өвийн бүртгэлийн нэгдсэн системийн үйл ажиллагааг шинэчлэх. | Улсын төсөв | Бүртгэн баримтжуулсан өвийн тоо | 2021 | Баримтат өвийн бүртгэлийн нэгдсэн системд бүртгэл хийгдээгүй байна. | Иргэдийн гар доорх 100-аас доошгүй баримтат өвийг бүртгэн баримтжуулсан байна | 2022 онд шинээр 60 баримтат өвийг нээж, Регистр" программд 35 хувийг нь бүртгэн баримтжуулан мэдээллийн санг баяжууллаа. | 50% |
| 6 | 5 | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх | Улсын төсөв | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн загвар, зураглал батлагдсан эсэх | 2021 | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих нөхцөл бүрдээгүй | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн загвар, зураглал, экосистемийн суурь загвар, зураглал экосистемийн суурь загвар, салбарын хамрах хүрээ, тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон байна | Засгийн газрын 2022 оны 314 дүгээр тогтоолоор батлагдсан "Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээ"-г баталсан бөгөөд орон нутагт "Бүтээлч авьяас чадварыг хөгжүүлэх", "Дэд бүтцийг нэмэгдүүлэх", "Дижитал шилжилтийг эрчимжүүлэх", "Сурталчилгааг нэмэгдүүлэх, хөхүүлэн дэмжих", "Мэдлэг, сайн туршлагаа солилцох" гэсэн үндсэн 5 чиглэлийн хүрээнд боловсруулалт хийж, аймгийн ИТХ-ын 2023 онд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Орон нутагт соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлын хүрээнд Жавхлант, Ерөө сумд "Сумын бренд бэлгийн багц бий болгох гар урлал өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх" төслийг хэрэгжүүлж, "Шүрэн эдлэл, наамал" үзэсгэлэн худалдаа, "Цагаан эсгийний баяр 2022" өдөрлөг, "Соёлын аялал жуулчлалын сар" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан. "Соёлын бүтээлч сар"-ын хүрээнд 26 байгууллага 300 гаруй арга хэмжээг зохион байгуулж, 9800 гаруй иргэдийг хамрууллаа. | 30% |
| 7 | 6 | Соёлын өвийн бүртгэл, хяналтын системийг хөгжүүлж мэдээллийн санг бүрдүүлэх.<br>. | Улсын төсөв | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн загвар, зураглал батлагдсан эсэх | 2021 | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих нөхцөл бүрдээгүй | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн загвар, зураглал, экосистемийн суурь загвар, зураглал экосистемийн | Соёлын яам, Шинжлэх Ухааны Академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран 5 бүлгийн 12 төрөлд судалгааны ажлыг хийж соёлын биет бус өвийг баримтжуулан, 492 соёлын биет бус өвийг өвлүүлэн уламжлуулагчийг мэдээллийн санд бүртгэн оруулсан. 2022 онд музейн бүртгэл мэдээллийн санд 6 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | суурь загвар, салбарын хамрах хүрээ, тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон байна | төрөл зүйлд хамрагдах 40 ширхэг биет үзмэрийг бүртгэн баримтжуулж, бүртгэл мэдээллийн санг баяжуулсан. | |
| **1.3 Монгол хэл, бичиг** | | | | | | | | |
| **Зорилт: Үндэсний Монгол хэл, бичгээ нийтээр сурч эзэмшин түгээн дэлгэрүүлнэ.** | | | | | | | | |
| 8 | 1 | Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг сайжруулах. | Улс, аймгийн төсөв | Үндэсний бичиг сурсан суралцагчдын эзлэх хувь, монгол бичгээр сургалт явуулах түвшинд хүрсэн багшийн хангалтын хувь, төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн шалгалтын улсын дунджаас ахисан хувь | 2021 | Монгол хэл бичгийн сургалтын чанарын үнэлгээг зохион байгуулах бэлтгэл ажлыг хийсэн | Монгол хэл бичгийн сургалтын чанарын үнэлгээнд дунд, ахлах анги төгсөгчдийг хамруулсан байна. Монгол бичгийн хэвлэмэл болон цахим сурах бичиг, гарын авлагыг боловсруулж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан байна. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, эх хэлээ эрхэмлэн дээдлэх үзлийг хойч үедээ өвлүүлэх үүднээс жил бүрийн 05 дугаар сарын эхний 7 хоногт “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын арга хэмжээг зохион байгуулж хэвшсэн. Мөн Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх, 2025 оноос төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага албан бичгээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан аймгийн хэмжээнд “Үндэсний бичигтэн 2022-2024” хөдөлгөөн” арга хэмжээг зохион байгуулж, байгууллага бүрт үндэсний бичгээ эрхэмлэн дээдлэх, сурч судлах ажлыг өрнүүлэхийг уриалан ажиллаж байна. Төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших ажлын бэлтгэл хийгдэж, Хэлний бодлогын салбар зөвлөлөөс стандартыг гарган байгууллагуудад чиглэл хүргүүлсэн. | 70% |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ** | | | | | | | | |
| **Зорилго:Иргэдийн эрүүл энх амьдрах, сурах, хөдөлмөрлөх боломжид суурилан нийгмийн баталгааг бий болгоно.** | | | | | | | | |
| **2.1. БОЛОВСРОЛ** | | | | | | | | |
| **Зорилт: Хүүхэд багачууд, иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлнэ.** | | | | | | | | |
| 9 | 1 | Зарим цэцэрлэгүүдэд хувилбарт сургалтад 150 хүүхдийг, 5 настай хүүхдийг цэцэрлэгт 100 хувь хамруулах | Улс, аймгийн төсөв | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь | 2021 | 2020, 2021 онд дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас хувилбарт сургалтыг хичээллээгүй. 11 цэцэрлэгийн 24 | Хувилбарт сургалтын 11 бүлэг ажиллуулж, 150 хүүхэд хамруулсан байна. Цэцэрлэгт хамрагдалтын хувийг 79,3 хувьд | Хувилбарт сургалтад 286 хүүхдийг хамруулж, 24 цагийн бүлэг шинээр нээгээгүй болович 2022 онд хамран сургалт өмнөх оныхоос 3.2% хувиар өссөн үзүүлэлттэй байна. | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цагийн 14 бүлэгт 301 хүүхэд хамрагдсан. Нийт хамран сургалт 79.2 хувьтай | хүргэсэн байна | | |
| 10 | 2 | Бага, дунд боловсролын чанарын болон суралцагчийн сургалтын ахиц, дэвшлийн үнэлгээг, тогтмол хийж, хоцрогдлыг арилгах цогц төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | Улс, аймгийн төсөв | Бага, суурь, бүрэн дунд боловсролын шалгуурт суурилсан шалгалт, хөндлөнгийн үнэлгээний гүйцэтгэлийн хувь, элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноосны өсөлт, бууралтын хувь | 2021 | Бага, дунд ангид суралцагчдын унших чадварын түвшин 85%. бичих чадварын түвшин 76%, математик чадварын түвшин 82%, дунд ангийн суралцагчдын ерөнхий чадварын түвшин 70%, ахлах ангийн суралцагчдын сонгон судалсан хичээлийн эзэмшилтийн түвшин 80% байна. | Суралцагчдын сурлагын амжилтын өсөлт 5 хувь болсон байна. Бага, дунд, ахлах ангийн суралцагчдын сонгон судалсан хичээлийн эзэмшилтийн түвшин өмнөх онтой харьцуулбал тус тус 5-10 хувиар өссөн байна | Оношлох үнэлгээгээр улсын дундаж /40.46/-аас 1.02 хувиар дээгүүр, элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж өнгөрсөн жил /503.7/-ийнхээс 2.9 хувь ахисан байна. | 70% |
| 11 | 3 | "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлэх | Улс, аймгийн төсөв | Багшийн мэргэжлийг дээшлүүлэх нөхцөл бүрдүүлсэн сургууль,цэцэрлэгийн эзлэх хувь, мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн багшийн тоо, хүүхэд бүрийг хөгжүүлэх арга зүй, тэргүүн туршлага түгээсэн багш | 2021 | Монгол Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 24 тоот тогтоолоор "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлж мэргэжлийн стандартыг | "Чадварлаг багш"арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар батлуулж, хэрэгжүүлж эхэлнэ. | Цахим платформд суурилан зохион байгуулагдаж буй багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих модуль сургалт “Aplus платформ” дээр зохион байгуулагдаж, мэргэжлийн багш нар өөрсдийн хэрэгцээнд үндэслэн “Багшийн мэргэшлийн хөгжлийг дэмжих, СӨБ болон ЕБС-ийн 14 судлагдахууны хөтөлбөрийн модуль-83, “Удирдах ажилтны хөгжлийг дэмжих сургалтын модуль-7, “Багш, ажилтны мэргэжлийн болон хувь хүний хөгжлийг дэмжих сургалтын модуль“ 20 сэдвээр давхардсан тоогоор СӨБ-ын 301, ЕБ-ын 1134 багш сонгон сургалтад хамрагдлаа. Үндэсний үндсэн сургалтад 134 багш, 29 ажилтан, орон нутгийн | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | нарын ээзлэх хувь, сургалтын шинэ арга зүй, технологи нэвтрүүлсэн багшийн эзлэх хувь | | нэвтрүүлэн, үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд шилжүүлэхээр заасан | | сургалтад 1210 багш, цахим сургалтад 2890 багш хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн. | |
| 12 | 4 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийг ялгаатай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлж, суралцагчийн онцлогт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж, сургалтын орчныг бүрдүүлэхэд бүх шатны байгууллагад дэмжлэг үзүүлэх | Улс, аймгийн төсөв | Мэргэжил дээшлүүлсэн багшийн тоо сургалтын орчин бүрдүүлсэн сургууль цэцэрлэгийн тоо | 2021 | Ерөнхий боловсролын сургууль дээр байгуулагдсан "Хүүхэд хөгжлийн загвар танхим"-д ажиллах багш, удирдах ажилтнуудыг чадавхжуулах сургалтад "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад чадавхжуулах" сургалтаар нийт 24 багшийг мэргэшүүлсэн. | Ерөнхий боловсролын сургуулийн 15, цэцэрлэгийн 10 багшийг мэргэшүүлсэн байна | 1 сургууль, 1 цэцэрлэгт жишиг танхимтай болгох ажлыг эхлүүлж, 70 багш нарыг мэргэшүүлэх сургалтад 2 удаа хамруулсан | 100% |
| 13 | 5 | Боловсролын цахим шилжилтийн хүрээнд боловсролын салбарын | Улс, аймгийн төсөв | Цахим сургалт явуулах боломжтой сургууль цэцэрлэгийн | 2021 | Боловсролын нэгдсэн сүлжээнд төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн | Нийт ерөнхий боловсролын сургуулийг боловсролын салбарын нэгдсэн сүлжээнд холбож, | Багшийн үндсэн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж, сургалтын платформын хөгжүүлэлт 5 хувьтай байна. Өндөр хурдны интернэтэд ерөнхий боловсролын сургуулийн 85,7 хувь, цэцэрлэгийн 65.9 хувь холбогдсон. | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэдээллийн систем, тоног төхөөрөмж, дэд бүтцийг үе шаттайгаар сайжруулж, цахим сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэх | | тоо, онлайн сургалтад хамрагдсан сурагч, иргэдийн тоо | | 85.7% холбогдсон. | өндөр хурдны интернэт үйлчилгээ үзүүлдэг болсон байна. Сургууль бүр edmodo платформыг хөгжүүлж, цахим сургалтыг өргөжүүлсэн байна. | Цахим сургуулийн сонгон судлах хичээлд 10 дугаар ангийн сурагчид хамрагдаж байна. | |
| 14 | 6 | Сургуулиудад ажиллах сэтгэл зүйчдийг бэлтгэх ажлыг эхлүүлэх | Улс, аймгийн төсөв | Сэтгэл зүйчээр хангагдсан сургууль, цэцэрлэгийн тоо | 2021 | 1 сургуульд сэтгэл зүйч ажиллаж байна | Боломжтой сургуульд сэтгэл зүйчийг үе шаттайгаар бэлтгэж, ажиллуулж, эхэлсэн байна. Сэтгэл зүйч нь сурагчидтай ажилласнаар дасан зохицох чадвар нэмэгдэж, эерэг хандлага бий болгон, бэрхшээлийг даван туулах чадварт сургах боломжтой юм. Ингэснээр хүүхдүүдийн сурах идэвх, сурлагийн амжилт нэмэгдсэн байна. | Ерөнхий боловсролын 6 сургуульд сэтгэл зүйч ажиллаж, хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, багш ажилтнууд сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлж тэдний өмнө тулгарсан саад, бэрхшээлийг эрсдэлгүй даван туулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна | 90% |
| 15 | 7 | Цэцэрлэг дотуур байрны хүүхдийн хоолны өдөрт авбал зохих илчлэг, шим тэжээлийн хэрэгцээг хангахуйц хоолоор үйлчлэх | Улс, аймгийн төсөв | Хүүхдийн биеийн онцлогт тохирсон шим тэжээллэг хоол хүнсээр үйлчлэх боломж бүрдүүлсэн | 2021 | Нөхцөл байдлын судалгааг хийж, судалгааны үр дүнгээр хүүхдийн хоолны зардлын нормативыг үе шаттайгаар нэмэгдүүлэх тооцоог хийсэн. | Хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон шим тэжээллэг хоол хүнсээр үйлчлэх боломж бүрдсэн байна. Цэцэрлэгийн хүүхэд болон | "ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 17 сумын ерөнхий боловролын 35 сургуулийн хүнсний хангамжийг тухайн орон нутгийн нийт 42 аж ахуйн нэгж, 4 ББН, 16 иргэнтэй байгуулсан гэрээ, чанар, аюулгүй байдал, стандарт шаардлага хангасан, малын гарал үүсэл, шинжилгээний бичигтэй түүхий эд, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эсэх | | Цэцэрлэгийн 7480 хүүхэд, дотуур байрны 1249 хүүхэд хамрагдсан. | сургуулийн дотуур байрны суралцагч 100% хамрагдсан байна. | хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, нийлүүлж, цэцэрлэг, дотуур байрны суралцагчдыг 100 хувь хамруулан ажиллаж байна. | |
| 16 | 8 | Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн суралцагчдыг үдийн хоолны үйлчилгээнд хамруулах, мэргэжлийн хүний нөөцөөр хангах | - | Хүний нөөцөөр бүрэн хангагдсан сургуулийн тоо | 2021 | Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн суралцагчдад үдийн цайны үйлчилгээг хүргэж байна. "Үдийн цай" хөтөлбөрт 10832 суралцагч хамрагдсан. Ахлах тогооч 100%, туслах тогооч 95%, угаагч 75 %, үйлчлэгч 76%-тай байна. Хоол зүйч одоогоор байхгүй. | 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн суралцагчдыг, 2022-2023 оны хичээлийн жилээс дунд ангийн суралцагчдыг үдийн хоолны үйлчилгээнд бүрэн хамруулсан байна. Хүний нөөцийн хангалт өмнөх онтой харьцуулбал 10 хүртэлх хувиар өссөн байна. | "Үдийн цай" хөтөлбөрийг "Үдийн хоол" хөтөлбөр болгон хэрэгжүүлж 1500 төгрөгөөр тооцож, аймгийн 35 сургууль нь өөрсдийн хоолны газартаа хоол үйлдвэрлэж байна. Аймгийн хэмжээнд бага ангийн 10924 хүүхэд "Үдийн хоол" хөтөлбөрт хамрагдаж өдөр бүр халуун хоол, цайгаар үйлчилж байна. 2022-2023 оны хичээлийн жилээс дунд ангийн суралцагчдыг үдийн хоолны үйлчилгээнд бүрэн хамруулах боломжгүй тул тус заалт улсын хэмжээнд хойшлогдсон болно.<br>2022 оны 10 дугаар сард Хоолзүй, шим судлалын Монголын нийгэмлэгтэй хамтран Хүүхдийн хоолны тогоочийн мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж 43 цэцэрлэг, 35 сургуулийн нийт 120 тогоочийг хамруулсан. "Ерөнхий боловсролын сургууль /дотуур байрны нэг хүүхдэд ногдох хоолны бодит өртгийг тооцох, өрхийн хүн ам зүй, нийгэм эдийн засгийн онцлогоос хамаарч эцэг эх, асран хамгаалагч зардлыг хариуцах хувилбарт шинжилгээ хийх" судалгааны ажлыг Боловсролын ерөнхий газар, "Статистик дэвшил" ТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж Сүхбаатар сумын нэгдүгээр сургуульд судалгаа хийж ажилласан. | 90% |
| 17 | 9 | Шинээр өргөтгөл баригдах 2 сургуулийн зураг төсөвт зориулалтын гал тогоог тусгах, зарим сургуулийг стандартын | Улс, аймгийн төсөв | Хоол үйлдвэрлэлийн зориулалтын байртай болсон сургуулийн тоо, техниз | 2021 | 11 сургууль зориулалтын байргүй, 8 сургууль стандартын шаардлага хангасан тоног | Ерөнхий боловсролын сургуулиудад хоол үйлдвэрлэлийн аюулгүй орчин бүрдсэнээр эрүүл, шим тэжээллэг хоол хүнсээр | Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж" арга хэмжээний хүрээнд 2021-2022 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургууль, дотуур байранд 215.0 сая төгрөгийн, цэцэрлэгт 213.6 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжөөр хангаж, хоол үйлдвэрлэл үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр хангах | | тоног төхөөрөмжийг шинэчилсэн сургуулийн тоо | | төхөөрөмжгүй байна | хангах нөхцөл бүрдсэн байна. | байна. | |
| 18 | 10 | Зарим сургууль цэцэрлэгийн барилга байгууламж, дотуур байранд их засвар хийх | Улс, аймгийн төсөв, гадаадын зээл тусламж, улсын төсөв 3.250,0 сая төгрөг | Их засвар хийгдсэн сургууль, цэцэрлэгийн тоо | 2021 | 7 сургууль, 11 цэцэрлэг, 1 дотуур байрны төсөл, тооцоолол техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн байна. | Тэгш хүртээмжтэй чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Цагааннуур сумын ЕБС-д 320 хүүхдийн өргөтгөл, Мандал суманд 480 хүүхдийн хичээлийн байр худалдан авах, Баруунбүрэн суманд НТБ-ын төвийн байр барих, Сүхбаатар сумын 4 дүгээр багт 200 хүүхдийн цэцэрлэг шинээр барьж эхэлнэ. Мөн аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Мандал сумын 4 дүгээр сургууль, Алтанбулаг сумын сургуулийн дээврийн засварын ажлууд хийгдсэн байна. | Цагааннуур суманд 320 хүүхдийн суудалтай хичээлийн барилга, Сүхбаатар сумын 4 дүгээр багт 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлж, 2023 онд ашиглалтад хүлээн авах бөгөөд улсын төсвөөр Мандал суманд 480 хүүхдийн хичээлийн байр худалдан авч, Баруунбүрэн суманд НТБ-ын төвийн барилгын ажил эхлээгүй байна. Орон нутгийн 190.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мандал-4-р сургууль, Алтанбулагийн дээврийг засварлалаа. Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэг, Мандал сумын 1 дүгээр сургуулийн их засвар, Сайхан сумын 3, Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгүүдийн их засварын ажил хийгдэж байна. Сүхбаатар сумын Засаг даргын нөөцөөс 16.0 сая төгрөгөөр 2 дугаар цэцэрлэгийн дээврийн засварын ажлыг шийдвэрлэсэн. 2021-2022 онд улс болон аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5 сургууль, 1 дотуур байр, 2 цэцэрлэгийн барилгын их засвар хийгдэж, 1 сургууль, 2 цэцэрлэгийн барилгын их засвар он дамжин хийгдэж байна. | 50% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | 11 | Ерөнхий боловсролын сургуулиудыг эрэгтэй, эмэгтэй технологи, хими физикийн кабинетийн хэрэглэгдэхүүнээр хангах | Улсын төсөв 800.0 сая төгөрг | Кабинетийн хэрэглэгдэхүүнээр хангагдсан сургуулийн тоо | 2021 | Төсөл тооцоолол, техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн | Ерөнхий боловсролын 25 сургуулийг эрэгтэй технологи, 10 сургуулийг эмэгтэй технологи, 11 сургуулийг хими, 17 сургуулийг физикийн хичээлийн хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангана | Ерөнхий боловсролын 31 сургуульд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 170,2 сая төгрөгийн технологийн кабинетаар хангасан. Монгол Улсын Боловсролын их сургууль, аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний хүрээнд багшийн заах арга зүй, ур чадварыг хөгжүүлэх, суралцагчийн сурлагын амжилтыг ахиулах зорилгоор Сүхбаатар сумын 1,2,3,4,5 дугаар сургууль, Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийг 54.0 сая төгрөгийн үнэ бүхий физикийн хичээлийн кабинетаар хангахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна. | 70% |
| 20 | 12 | Зарим сумдад шинэ цэцэрлэг, сургууль барих ажлыг эхлүүлэх | Улсын төсөв 1,000.0 сая төгрөг | Ашиглалтад орсон барилгын тоо | 2021 | 2022 оны улсын төсөвт Сүхбаатар сумын 4 дүгээр багт барих 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлэхээр тусгасан. | Зураг төсөв хийгдэж барилгын ажил эхэлсэн байна | Сүхбаатар сумын 4 дүгээр багт 200 хүүхдийн цэцэрлэг, Цагааннуур суманд 320 хүүхдийн суудалтай хичээлийн барилгын гадна дулаан, цэвэр бохир усны шугамын ажил буюу тухайн онд гүйцэтгэх ажил хийгдсэн. Мандал суманд сургалтын үйл ажиллагаа явуулж байсан хувийн сургуулийн хичээлийн байрыг төрд худалдан авч үйл ажиллагаа нь эхэлсэн. Сүхбаатар сумын 4, Мандал сумын 3 дугаар сургуулийн хичээлийн байрны өргөтгөлийн ажил гүйцэтгэх компанитай гэрээ цуцлагдсан. Ерөө, Түшиг сумын цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэл дууссан. | 100% |
| **2.2. Эрүүл мэнд** | | | | | | | | | |
| **Зорилт: Эрүүл мэндийн бодлогыг чанартай, хүртээмжтэй, үр дүнтэй хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 21 | 1 | 1. Цар тахлын үеийн бэлэн байдал, эм нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, оношлуур бамбарын нөөц бүрдүүлэлт, тоног төхөөрөмж, | Улс, аймгийн төсөв | Нөөц бүрдүүлэлтийн хувь | 2021 | Эм нэг удаагийн хамгаалах хэрэгслийн 15 хоногийн нөөцтэй, тусгаарлах байранд ажиллах 10 эмч эмнэлгийн мэргэжилтний | Орон нутагт дэлгэсэн ковидын эмчилгээний 15 тасагт ажиллах 60 эмч, эмнэлгийн мэргэжилтний нөөц бүрдүүлэх, лабораторийн 1 их эмч бэлтгэх, эрчимт | Цар тахлын үеийн бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд Ковидын эмчилгээний тасагт дайчлагдан ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. -Төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалтанд нэн шаардлагатай лабораторийн их эмч, эрчимт эмчилгээний их эмч, эсийн эмгэг судлалаар тус бүр 1 их эмч мөн халдвартын сувилахуй 2, яаралтай | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дайчлагдан ажиллах хүний нөөц, хариу арга хэмжээг төлөвлөх хэрэгжүүлэх | | | | багтай АНЭ болон МСНЭ-үүд тархвар судлагч болон вируслогич эмчгүй | эмчилгээний 1 их эмч бэлтгэх, яаралтай тусламж эрчимт эмчилгээний сувилахуй, ариутгагч бэлтгэх | сувилахуй судлал 1, дархлаажуулалт, гемодиализын сувилахуй судлал, гэмтлийн сувилахуй, мэс заслын сувилахуй судлалаар нийт 10 сувилагчийг төрийн сангийн санхүүжилтээр сургаснаар тусламж, үйлчилгээний чанар сайжирч байна. | |
| 22 | 2 | 2. Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг орон нутгийн төсвийн боломжид үндэслэн төлөвлөн батлуулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, халдвар хамгааллын хэрэгслээр мэргэжлийн байгууллагуудыг хангах | Улс, аймгийн төсөв | Техник тоног төхөөрөмж халдвар хамгааллын хэрэгслээр хангасан эсэх | 2021 | Бүх шатны эмнэлгүүдэд хүчилтөрөгч өтгөрүүлэгч 42 ш нийлүүлэгдсэн, зөөврийн ЭХО аппарат Түнхэл тосгонд, сум тосгон өрхийн ЭМТ-үүд нийт 26 нэгжид мобайл технологийн тоног төхөөрөмжийн иж бүрдэл нийлүүлэгдсэн | Цар тахлын үед хэрэглэх шаардлагатай, эм эмнэлгийн хэрэгсэл багаж тоног төхөөрөмж оношлуур басад хэрэгсэл худалдан авахад зарцуулагдах төсөв батлагдаж, Сайхан, Ерөө сумын ЭМТ-үүд зөөврийн дижитал рентгэн аппараттай болсон байна | “Дезерет” Олон Улсын энэрлийн байгууллагаас 5 төрлийн 80 ширхэг нярайн тоног төхөөрөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад нийлүүлснээр анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эх, нярайн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэж байна. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/414 тушаалын дагуу бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад 10 төрлийн 80026 эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж хувиарласнаар эм эмнэлгийн хангалт нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/519 тоот тушаалын дагуу бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад 15 төрлийн 127620 эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж хуваарилан ажилласан | 100% |
| 23 | 3 | 3. Томуу, томуу төст өвчин, улаанбурхан улаанууд зэрэг амьсгалын замын халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийг хамруулах ажлын зохион байгуулах | Улс, аймгийн төсөв | Дархлаажуулалтад хамрагдсан хүүхдүүдийн хувь | 2021 | Амьсгалын замын өвчлөлийн дэгдэлтийн үед томуу томуу төст өвчин, улаанбурхан улаанууд дархлаажуулалтад 0-15 насны хүүхдүүдийн хамрагдалт 100% | Томуу, томуу төст өвчин, улаанбурхан улаанууд өвчний өвчлөл буурсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/512 тоот тушаалын дагуу Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дархлаажуулалтыг 1-12 нас, жирэмсэн эх, эрүүл мэндийн байгууллагын ажилчид, эрсдэлт бүлгийн хүн хийхээр төлөвлөж 1-12 насны цэцэрлэгийн насны 6450 хүүхдэд хамрагдахаас 4355 хүүхэд буюу 67,5 хувьтай хамрагдсан байна. Товлолын дархлаажуулалтын хамралт 99 хувьтай байна. Улаанбурхан, улаануд, гахай хавдрын өвчлөл гараагүй байна. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 24 | 4 | 4. Хүн амын дунд эрт илрүүлэг үзлэг, халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх оношилгоо, шинжилгээг тасралтгүй зохион байгуулж эрүүл мэндийг дэмжих тусламж үйлчилгээг үзүүлэх | Улс, аймгийн төсөв | Үзлэг оношилгоонд хамрагдсан иргэдийн тоо | 2021 | Халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх цогц үзлэг, оношилгоонд аймгийн 75,700 иргэн хамрагдаж, 10% нь эрт үедээ оношлогдож эмчилгээ хяналтад орсон | 2022 онд 26,000 иргэнийг эрт илрүүлэг болон халдварт, халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх цогц үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах | Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, 6 багц оношилгоо шинжилгээнд 113,325 иргэн хамрагдахаас өнөөдрийн байдлаар 20681 иргэн хамрагдаж, хамралт 18,2 хувь байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт насанд хүрэгчдийн буюу 18-аас дээш насны эрт илрүүлэгт 74586 иргэн хамрагдахаас 3126 иргэн хамрагдаж хамралт 4,2 хувьтай байна. Насанд хүрэгчдийн 4 эрт илрүүлгийн багц буюу 18-30 насанд 21908 иргэнд хамрагдахаас 1411 иргэн хамрагдаж хамралт 6,4 хувь, 31-45 насанд 24774 иргэнд хамрагдахаас 745 иргэн хамрагдаж хамралт 3 хувь, 46-60 насанд 19074 иргэнд хамрагдахаас 655 иргэн хамрагдаж хамралт 3,4 хувь, 61-ээс дээш 8793 иргэнд хамрагдахаас 325 иргэн хамрагдаж хамралт 3,7 хувьтай хамрагдсан байна. Анхан шатны Эрүүл мэндийн байгууллага буюу сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвд 0-17 насны 38739 хүүхэд эрт илрүүлэг үзлэг оношилгоонд хамрагдахаас 17555 хүүхэд хамрагдаж хамралт 45,3 хувьтай байна. Эрүүл идэвхтэй амьдрал, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний талаарх мэдээлэл, сургалт сурталчилгааг олон талт хэлбэрээр танхим болон цахим, ажлын байранд нь зохион байгуулж давхардсан тоогоор нийт 153 байгууллага, 23827 иргэн, ажилтан албан хаагчийг хамруулсан. | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 25 | 5 | 5. Мандал сумын нэгдсэн эмнэлэгт вируслогийн лаборатори байгуулах | Улс, аймгийн төсөв | Ашиглалтад орсон лабораторийн тоо | 2021 | Мандал сумын нэгдсэн эмнэлэгт вируслогийн лабораторигүй | Мандал сумын нэгдсэн эмнэлэгт вируслогийн лабораторийг шинээр нээж ажиллуулснаар Ковид-19 цар тахлын үед Хараа бүсийн сумдын иргэдийн шинжилгээг хийж хүлээгдэл чирэгдэл багасаж цаашид бцсад вируслогийн шинжилгээнүүдийг орон нутагтаа хийх боломж бүрдүүлэх | Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн вируслогийн лабораторийн санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй. Эрүүл мэндийн яамнаас тоног төхөөрөмж одоогоор нийлүүлэгдээгүй байна. Тус лабораторт ажиллах мэргэшсэн хүний нөөцийг сурган бэлтгэсэн. | 30% |
| 26 | 6 | 6.Шинэ коронавируст халдварын дараах хяналт болон уушигны эмгэг илрүүлэх “Эрүүл амьдралын төлөө хамтдаа” үзлэг оношилгоог бүх сум тосгонд зохион байгуулах. | Улс, аймгийн төсөв | Үзлэгт хамрагдсан иргэдийн хувь | 2021 | Улсын хэмжээнд 2020 оны байдлаар сүрьеэгийн 3339 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь олон улсын байгууллагын тооцсон нийт өвчлөлийн 31 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, улсын хэмжээнд 8000 гаруй сүрьеэтэй өвчтөн оношлогдоогүй буюу илрээгүй байна.<br>Манай аймгийн хэмжээнд 2021 оны 10 дугаар сарын байдлаар сүрьеэгийн 57 шинэ тохиолдол | Шинэ коронавируст халдвараар өвдөөд эдгэсэн иргэд үзлэг оношлогоонд хамрагдаж ковидын дараах хяналтад орсон байна. -Уушигны эмгэг илрүүлэх үзлэгт зорилтот бүлгийн иргэд хамрагдаж эмчилгээ хяналтад орсон байна | Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Эрүүл мэндийн сайдын баталсан журмын дагуу Глобал сан, Монголын сумын эмч мэргэжилтний холбооны санхүүжилтээр “Уушгины эмгэг илрүүлэх, сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэг"-ийг Алтанбулаг, Жавхлант, Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Хушаат, Ерөө, Хүдэр, Сайхан, Орхон, Баруунбүрэн, Орхонтуул сум, Рашаант, Бугант, Дулаанхаан тосгон, Хилийн цэргийн 0101 дүгээр анги, Гааль, Гадаадын иргэн харьяатын газрын хойд бүс дэх газрын албан хаагчдад буюу эрсдэлт бүлгийн нийт 2302 хүний рентген шинжилгээнд хамруулахад 53 хүний зураг өөрчлөлттэй гарч сүрьеэгийн шинэ тохиолдол 6 батлагдан эмчилгээ хяналтад оруулсан. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүртгэгдсэн нь өмнөх оныхоос даруй 49 тохиолдлоор бага байгаа нь цар тахлын улмаас илрүүлэг үзлэг хийгдээгүйтэй холбоотой байна. | | | |
| 27 | 7 | 7.Иргэд, олон нийтэд “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлыг эрчимжүүлэх | Улс, аймгийн төсөв | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, түүнд хамрагсдын тоо | 2021 | “Халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хийж байгаа боловч шинээр мутацлагдсан хувилбарууд гарч ирж байна. -Телевиз болон цахимаар сэрэмжлүүлэг нэвтрүүлгийг бэлтгэж иргэдэд сурталчлах шаардлагатай | Иргэд халдварт цар тахлаас сэргийлэх, хэрхэн халдвар хамгааллын дэглэмийг мөрдөх талаарх мэдлэгтэй болж хэрэгжүүлж хэвшсэн байна | 2022 онд 3 телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. Мөн байгууллагын албан ёсны цахим хуудсаар дамжуулан ”Эмч зөвлөж байна” булангаар 268 төрлийн мэдээлэл, сургалт сурталчилгааг 536125 хүнд хүргэж 45982 хүн бусадтай хуваалцаж эрүүл мэндийн боловсрол олгосон. Ингэснээр иргэдийн Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг хандлага нэмэгдсэн. | 100% |
| 28 | 8 | 8. Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, “Эрүүл идэвхтэй амьдрал”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх”, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл | Улс, аймгийн төсөв | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, түүнд хамрагсдын тоо | 2021 | Ковид цар тахалтай холбоотойгоор эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг дадал болгох шаардлага тулгарч байна | Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшиж “Эрүүл, идэвхтэй амьдрал”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх”, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хавдрын | Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшиж “Эрүүл, идэвхтэй амьдрал”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх”, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн Монгол”, “Харшлаас сэргийлэх”, “Эрүүл гэр бүл-Эрхэм баян” арга хэмжээнүүдийн хүрээнд 92 арга хэмжээ төлөвлөснөөс 2022 онд 56 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэнд”, “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн Монгол”, “Харшлаас сэргийлэх”, “Эрүүл гэр бүл-Эрхэм баян” арга хэмжээг зохион байгуулах. | | | | | эсрэг”, “Элэг бүтэн монгол”, “Харшлаас сэргийлэх”, “Эрүүл гэр бүл-Эрхэм баян” арга хэмжээнүүд зохион байгуулагдсан байна | | |
| 29 | 9 | 9. Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд цахим технологийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах. | Улс, аймгийн төсөв | Мэдээллийн цахим сангийн баяжилтийн хувь, цахим сүлжээний орчин бүрдүүлсэн эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь | 2021 | Цахим технологийг нэвтрүүлж байгаа боловч уг ажлыг эрчимжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах шаардлагатай | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд цахим технологи нэвтэрч, чанар, хүртээмж нь сайжирсан байна | “Axis systems” ХХК-ий “E-hospitals.mn” цахим платформыг эрүүл мэндийн 28 байгууллагад ашиглаж, эрүүл мэндийн даатгалын цахим программ “ehealth” программтай холбож эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж ажиллаж байна. Эмч, эмнэлгийн мэргэжилтний программын хэрэглээг сайжруулахтаы холбогдуулан үе шаттай шаталсан сургалтыг цахимаар хөгжүүлэгч компани сургагч багш нараас авч ажиллаж байна | 70% |
| 30 | 10 | 10. Зарим сумын Эрүүл мэндийн төвүүдийг шүдний эмчээр хангаж, шүдний кабинеттэй болгох | Улс, аймгийн төсөв | Эмчийн хангалтын хувь, ашиглалтад орсон шүдний кабинетын тоо | 2021 | Сумын эрүүл мэндийн төвүүдэд шүдний кабинет нэн шаардлагатай | Сумын эрүүл мэндийн төвүүдэд шүдний эмчээр хангагдаж шүдний эмчийн тусламж, үйлчилгээг авч эхэлнэ | Иргэний 22.0 сая төгрөгийн хандиваар Цагааннуур суманд эрүүл мэндийн төв шүдний тоног төхөөрөмжтэй болж, үзлэг оношлогоог хийх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. "Эрүүл-шүд" хүүхдийн шүдний өвчлөлийг эрт илрүүлэн, эмчлэх үзлэгийг явуулын хэлбэрээр зохион байгуулж Сүхбаатар, Зүүнбүрэн сумын 730 хүүхдийг хамруулан 342 хүүхэд, шүдний өвчлөлтэй илэрч 100 хувь эмчилгээ хийлгэсэн. УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбатын санаачлагаар “Мишээл” хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр "Сайхан инээмсэглэлийг хүүхэд бүрт" үзлэгийг Орхон, Ерөө бүсийн сумдын ИТХ, Засаг даргын Тамгын газартай хамтран хүүхдийн шүдний үзлэгийг үнэ төлбөргүй зохион байгуулж нийт 1284 хүүхдийг үзлэг, болон эмчилгээнд хамруулсан. | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 31 | 11 | 11.1.Эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламжийг шинээр барих ажил | Улс, аймгийн төсөв | Ашиглалтад орсон барилгын тоо | 2021 | Эрүүл мэндийг дэмжих төвийн барилга шинээр барих 1,8 тэрбум төгрөгний ажил | Эрүүл мэндийг дэмжих төвийн барилга шинээр баригдсан байна | Улсын төсвийн 1,800.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн газрын барилгын тендер шалгаруулалтад гүйцэтгэгч байгууллага шалгараагүй тул 2023 оны улсын төсөвт шинэчилсэн зураг төсвийн өртгийг батлуулах хүсэлт өгөөд байна. | 30% |
| | | | Улс, аймгийн төсөв | Ашиглалтад орсон барилгын тоо | 2021 | Цагааннуур сумын ЭМТ-ийн 15 ортой өргөтгөлийн барилга барих 513 сая төгрөгийн ажил | Цагааннуур сумын ЭМТ-ийн 15 ортой өргөтгөлийн барилга баригдсан байна | Цагааннуур сумын эрүүл мэндийн төвд 513.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 15 ортой эмнэлгийн өргөтгөлийн барилгын сонгон шалгаруулалтыг 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр зарлаж, 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр нээгдэж, гүйцэтгэгчээр “ДЕВСОФТ” ХХК шалгаран барилгын ажил хийгдэж байна. | 70% |
| | | | Улс, аймгийн төсөв | Ашиглалтад орсон барилгын тоо | 2021 | Жавхлант сумын ЭМТ-ийн 5 ортой өргөтгөлийн барилга барих 279.9 сая төгрөгийн ажил | Жавхлант сумын ЭМТ-ийн 5 ортой өргөтгөлийн барилга баригдсан байна | 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр нээгдэж, гүйцэтгэгчээр “ДЕВСОФТ” ХХК шалгарсан. Жавхлант сумын эрүүл мэндийн төвд 284,200,000 төгрөгийн 5 ортой өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “Перфект смайл” ХХК нь шалгарч, барилгын явц 85 хувьтай байна. | 100% |
| 32 | 12 | 12.2.Эрүүл мэндийн байгууллагуудын барилгын их засварын ажил | Улс, аймгийн төсөв | Их засвар хийгдсэн эсэх | 2021 | Аймгийн нэгдсэн эмнэлгийн дотор сантехникийн засварын 2 тэрбум 735 сая төгрөгийн ажил | Аймгийн нэгдсэн эмнэлгийн дотор сантехникийн засвар хийгдсэн байна | 2022 оны 11 сарын байдлаар Улсын төсвийн 2,735.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилгын дотор сантехникийн их засварын ажлыг 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр зарлаж, 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдөр нээгдэж, гүйцэтгэгчээр “НОЁН-ӨНДӨР КОНСТРАКШН” шалгарч, ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна. | 90% |
| | | | | | | Дулаанхаан тосгоны ЭМТ-ийн барилгын их засварын 77,8 сая төгрөгийн ажил | Дулаанхаан тосгоны ЭМТ-ийн барилгын их засварын ажил хийгдсэн байна | Шаамар сумын Дулаанхаан тосгоны Эрүүл мэндийн төвд 77,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар эмнэлгийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгчээр "ESBI" ХХК шалгарч 2020 оны 08 дугаар сарын 20-нд ажлаа эхэлж, барилгын ажил бүрэн дууссан | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 33 | 13 | 13.1.Эрүүл мэндийн байгууллагуудыг эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангах. | Аймгийн төсөв | Тоног төхөөрөмжөөр хангагдсан байгууллагын тоо | 2021 | Сайхан, Ерөө сумдын Эрүүл мэндийн төвүүдийг зөөврийн рентгэн аппараттай болгох | Сайхан, Ерөө сумдын Эрүүл мэндийн төвүүдийг зөөврийн рентгэн аппараттай болсон байна | Сайхан сумын Эрүүл мэндийн төв нь байгууллагын төсвөөр рентген аппаратыг худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 2022 оны 11-р сард “Ай мед техноложис” ХХК хийж гүйцэтгэсэн. | 100% |
| | | | | | | Эрүүл мэндийн газар, Мандал сумын нэгдсэн эмнэлэг, Сайхан сумын эрүүл мэндийн төвд, уушигны багтаамж шалгах спирометр багаж авах 10,0 сая төгрөгийн ажил | уушигны багтаамж шалгах спирометр багажтай болсон байна | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/536 дугаар тоотын дагуу Баянгол, Сайхан, Ерөө сумдын Эрүүл мэндийн төвүүдэд уушгины багтаамж шалгах спирометр багаж болон дагалдах хэрэгслүүдийг нийлүүлсэн | 50% |
| | | | | | | Эрүүл мэндийн газрын зөөврийн дижитал рентген аппаратны зургийн хоолойг солих 15 сая төгрөгийн ажил | зөөврийн дижитал рентген аппаратны зургийн хоолойг шинээр авч аппаратыг хэвийн ажиллагаанд оруулсан байна | “Глобал” сангийн дэмжлэгтэйгээр Америкийн Нэгдсэн Улсын “Minxray” компаний инженерүүдээр гэмтэлийн үнэлгээ хийлгүүлэн, засвар үйлчилгээ хийж ашиглалтад оруулсан. | 100% |
| | 13 | 13.3.Эрүүл мэндийн байгууллагуудыг эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангах | | Ашиглалтад орсон эсэх | 2021 | Тунамал нарс зуны сургалтын төвд гүний худаг гаргах 20 сая төгрөгний ажил | Гүний худагтай болж ковидын халдварын дараах хяналт нөхөн сэргээх эмчилгээ үйлчилгээний чанар сайжирна | Алтанбулаг сумын Улаан бургаст байрлах Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн сургалтын баазад гүний худаг гаргах ажлын дагуу “Эвлэл” ХХК нь гүйцэтгэгчээр ажиллаж Улсын комисс хүлээж авсан. | 100% |
| 34 | 14 | 14.Мэргэжлийн өндөр ур чадвартай, туршлагатай нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтны гэрээний тусгай нөхцөлтэйгөөр | Улс болон орон нутгийн төсөв | Гэрээ байгуулсан эмч ажилчдын тоо, давтан сургалтад хамрагдсан эмнэлгийн ажилтны тоо | 2021 | Аймгийн нэгдсэн эмнэлэг нь 2021 оноос мэс заслын 1 эмчийг гэрээний тусгай нөхцөлтэйгээр ажиллуулж байна 16 эмч эмнэлгийн мэргэжилтэнг | Мэргэжлийн өндөр ур чадвартай, туршлагатай нарийн мэргэжлийн эмч эмнэлгийн ажилтныг гэрээний тусгай нөхцөлтэйгээр ажиллуулсан | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Томографикын аппараттай болж иргэд орон нутагтаа оношлогоо шинжилгээндээ хамрагдах бүрэн боломжтой болсон. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт томографиар мэргэшсэн эмч байхгүй тул “Улаанбаатар мэд” эмнэлгийн томографикийн эмчтэй гэрээ байгуулан ажиллаж байна. 2022 онд аймгийн Нэгдсэн эмнэлэгт урологи /бөөр, шээсний замын эмгэг/-ийн иж | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллуулах, туршлага судлуулах, давтан сургах арга хэмжээг үе шаттай зохион байгуулах | | | | төгсөлтийн дараах давтан сургалтад хамруулсан | эмнэлгийн мэргэжилтний тоо нэмэгдсэн байна. Давтан сургалтад хамрагдсан эмнэлгийн ажилтны тоо нэмэгдэж тусламж, үйлчилгээний чанар нэмэгдэнэ | бүрэн тоног төхөөрөмж суурилуулж улсын нэгдүгээр төв эмнэлгийн урологийн тасгийн эмч нар нарын баг ажлын байран дахь сургалтыг зохион байгуулж эмч, сувилагчийг дадлагажуулсан. 2022 онд Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдэд аймаг дүүргийн Нэгдсэн эмнэлгүүдийг хувиарласны дагуу манай Нэгдсэн эмнэлэг Улсын Гуравдугаар төв эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулан эмч, мэргэжилтэн солилцох, ажлын байрны дадлага сургалт, тусламж үйлчилгээний чиглэлээр хамтран ажиллаж байна. Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран ажиллах гэрээний дагуу хавдрын мэс заслын эмчийг тусгай нөхцөлт гэрээгээр орон нутагт ажиллуулах саналыг хүргүүлээд байна. | |
| 35 | 15 | 15.Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэгт вакуумжсан мэс заслын өрөө байгуулах асуудлаар Эрүүл мэндийн яаманд хүсэлт тавьж шийдвэрлүүлэх холбогдох төсөл хөтөлбөр хандив тусламжаар санхүүжүүлэх арга замыг судлах | Улс болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр | вакуумжсан мэс заслын өрөө байгуулагдсан эсэх | 2021 | вакуумжсан мэс заслын өрөөг шинээр байгуулах 506,0 сая төгрөгийн өртөгтэй зураг төсвийг хийсэн | Санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад саналыг уламжилсан байна | 506 сая төгрөгний өртөгтэй зураг төсвийн дагуу аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд батлуулж төсөвт суулгахаар санал хүргүүлэн ажиллаж байна. | 100% |
| **2.3. Гэр бүл** | | | | | | | | | |
| **Зорилт: Гэр бүл бүхэн өөрийн үнэт зүйлсээ дээдлэн хөгжүүлж, үр хойчдоо уламжлан үлдээж өвлүүлнэ** | | | | | | | | | |
| 36 | 1 | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд зохион байгуулж | Улсын төсөв | Хамрагдсан гэр бүлийн тоо, гэр бүлийн болон хүүхдийн эсрэг | 2021 | 3 цахим сургалтад 16 сумын 37 хамтарсан багийн 267 гишүүдийг | Хүчирхийллийн эрсдэл буурсан байна | “Хүчирхийлэлгүй аймаг” болох зорилтын хүрээнд “Монголын асрамж хамгаалал, нөхөн сэргээх төвүүдийн нэгдсэн холбоо” төрийн бус байгууллагатай хамтран 14 сум, 6 тосгоны 30 хамтарсан багийн 248 гишүүдэд ажлын байран дээр нь | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | “Хүчирхийлэлгүй аймаг” болох бодлогыг хэрэгжүүлэх | | хүчирхийллийн үйлдлийн тоо | | хамруулсан | | чадавхжуулах сургалт зохион байгуулсан “Миний гэр аюулгүй орчин” нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 384 сурагч хамрагдсан. “Сонгог хөрш” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд 3 төрлийн 3450 ширхэг постерыг олон нийтэд түгээсэн. “Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах” нөлөөллийн 6 арга хэмжээнд зорилтот бүлгийн 65 иргэнийг хамруулсан. Хүүхдийг болзошгүй эрсдэл, бие махбодын хүчирхийллээс ангид байхад сургах суурь чадварыг эзэмшүүлэх "Улаан гэрэл" сургалтад ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн 58, сургуулийн өмнөх боловсролын дунд бүлгийн 62 нийт 120 хүүхдийг хамруулсан. Өсвөр насны хүүхдийн онцлог, үе тэнгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нөлөөллийн сургалтад 26 сурагч хамрагдсан. Үр дүн: 5 нөлөөллийн арга хэмжээнд 4293 хүүхэд, насанд хүрэгч хамрагдаж гэр бүлийн хүчирхийллийг таних, түүнийг таслан зогсоох, даван туулах аргад суралцсан. | |
| 72 | 5 | 5. Иргэд, хүүхэд залуучуудад үйлчлэх спортын зориулалтын орчин нөхцөлийг сайжруулах | улсын төсөв 500,0 сая төгрөг, орон нутгийн төсөв 245,161,426 | ашиглалтад орсон барилгын тоо | 2021 | цэнгэлдэх хүрээлэн 17, спорт цогцолбор 8, нийт биеийн тамирын талбай 40, спорт заал 52 | ашиглалтад орсон барилгын тоо Баруун бүрэн цэнгэлдэх талбайн засвар, их засвар хийх заалоын тоо 4, спортын ордны гадна талын фасад, БТСГазар,усан спортын төсвийн оффисийн дээвэр, | Мандал суманд соёл, амралт, биеийн тамирын иж бүрэн талбайг шинээр байгуулан ашиглалтанд оруулж бүх талбайн хэмжээгээр бүрэн ашиглахад / сагсан бөмбөг, волейбол, элсний волейбол, чийрэгжүүлэх тренежорууд, хүүхдийн тоглоом / зөвхөн 1 цагт 52 хүн хамрагдаж ажлын 8 цагт 416 хүнийг чийрэгжүүлэн, бие бялдрыг хөгжүүлэн жилд 151840 хүнд үйлчилгээ үзүүлэх боломж нээгдсэн. Алтанбулаг суманд шинээр спорт цогцолборын барилга | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Баянгол, сайхан тоног төхөөрөмжөөр хангагдсан заалын тоо 2 ком, ширээ сандал Алтанбулаг сум дулаанхаан тосгон | баригдаж ашиглалтанд хүлээн авч ашиглалтыг сайжруулахаар орон тооны арга зүйчтэй болгох чиглэлээр Биеийн тамир спортын Улсын хороонд саналаа хүргүүлэн үр дүнд 4 арга зүйчтэй болон ажиллаж байна. Аймгийн ахмадын хороотой хамтран Грандгольфын спортыг шинээр хөгжүүлэх чиглэлээр техник хэрэгслийг авчран/ 12 цохиур, 10 бөмбөг, 5 ширхэг тугтай үүр,/ Сүхбаатар сумын 8 багуудын дунд хуваарь гарган зааж сурган, шинэ төрлийн спортын дүрэм, тоглох аргачлалыг зааж нийтдээ 200 гаруй иргэд хамрагдаж үр дүнг харуулсан анхны нээлттэй тэмцээнийг Сүхбаатар суманд зохион байгуулсан. Аймаг орон нутагт үйл ажиллагаа явуулдаг спортын 8 цогцолборт үйл ажиллагааг нь хэвийн хангах чиглэлээр 500000 төгрөгийн спортын бараа /сагсан бөмбөг, хөл бөмбөг, волейбол, волейболын тор, секундомер, шүгэл, онооны самбар/ нийлүүлэн 4000000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Сайхан, Ерөө, Цагааннуур, Баянгол, Спортын ордонд үйл ажиллагаа, эдэлгээг сайжруулах чиглэлээр урсгал засварын тендерүүдыг зарлан нийтдээ 730 гаруй сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн засвар үйлчилгээний ажил хийгдэж дууссан. | |
| **3.5. Газрын харилцаа** | | | | | | | | | |
| **Зорилт: Монгол Улсын газрын харилцаа, геодизи, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | |
| 73 | 1 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулах. | Гадаадын зээл тусламж, орон нутгийн төсөв | Аймгийн газар зохион байгуулалтын бодлогын баримт бичигтэй болсон эсэх | 2021 | “STREAM” төслөөс “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулах, санхүүжилтийг шийдвэрлүүлж, ажлын | Зам, шугам сүлжээ, инженерийн барилга, байгууламж, үйлдвэр уурхай, хөдөө аж ахуй салбарын хөгжлийн чиг хандлага тодорхойлогдоно | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан батлуулж, аймгийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэхээр “Вектор мэп” ХХК-тай шалгарч, СЭА01-22/2022 дугаартай гэрээг байгуулан суурь судалгааны ажлыг хийлгэж байна. | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даалгавар боловсруулсан | | | |
| 74 | 2 | Мандал, Зүүнбүрэн, Хүдэр, Шаамар, Орхон, Орхонтуул, Сант, Жавхлант сумдын хот байгуулалтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах. | Орон нутгийн төсөв | Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичигтэй болсон сумын тоо | 2021 | 2 сумын хот байгууллтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна | Албанбулаг сум хот байгуулалтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, сумдын хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулж батлуулсан байна | "STREAM" төсөлтэй хамтран сумдын хот байгуулалтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах санхүүгийн асуудлыг шийдвэрлэж, багийн иргэдийн Нийтийн хурлаар санал авч батлуулахаар ажиллаж байна. Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар Алтанбулаг сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг “Идеал Групп” ХХК хийж байна. Алтанбулаг сумын хот байгуулалтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлыг "Ланд Овнер" ХХК хийж гүйцэтгэсэн. Ерөө сум орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хийлгэхээр зургийн даалгаврыг боловсруулан мэргэжлийн байгууллагад хянуулахаар хүргүүлсэн. | 90% |
| 75 | 3 | 3. Барилга байгууламжийг паспортжуулах орон тооны бус зөвлөл байгуулж, паспортжуулах ажлыг эхлүүлэх | улс аймаг сумын орон нутгийн төсөв | Паспортжуулсан барилга байгууламжийн тоо | 2021 | Сүхбаатар сумын “Төрийн албан хаагчдын 120 айлын орон сууц”, бага зардалтай эрчим хүчний хэмнэлттэй 50 ортой цэцэрлэгийн барилга, Шаамар сум, Дулаанхаан тосгоны сургуулийн ариун цэврийн байгууламжийн барилгыг паспортжуулсан. | Барилга, байгууламжийн паспортжуулах орон тооны бус зөвлөл байгуулж, 3-аас доошгүй барилга байгууламжийг паспортжуулсан байна | 2022 онд Хүдэр сумын сургуулийн ариун цэвэр, халуун усны байгууламж, иргэн Д.Оюунсүрэнгийн худалдаа үйлчилгээний төв, Мандал сумын “Оюу болд“ ЗБН-ийн худалдаа үйлчилгээний барилга, Цагааннуур сумын “Товхон хан” ХХК-ий офиссын зориулалттай барилга байгууламж, иргэн Б.Элбэгзаягийн үйлчилгээний зориулалттай орон сууцны барилга, Ерөө сумын 960 хүүхдийн сургуулийн барилга, Мандал сумын “Өсөх буудай” ХХК-ий усны үйлдвэр, Сүхбаатар сумын иргэн Б.Оч-эрдэнэ, Б.Энхцэцэгийн нарын авто машины гараж, агуулах бүхий сэндвичэн барилга байгууламж, авто засварын барилга зэрэг 9 барилгад ногоон паспорт олгосон. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 76 | 4 | 4. Сүхбаатар сумын үерийн хамгаалалтын далан, авто замын ус зайлуулах системийн ажлын санхүүжилтийг шийдвэрлүүлэх | улс аймаг сумын орон нутгийн төсөв | санхүүжилтийг шийдвэрлэж, хийгдсэн эсэх | 2021 | Сүхбаатар сумын үерийн хамгаалалтын далан, авто замын ус зайлуулах системийн ажлын зураг төсөл боловсруулсан | Шаардлагатай санхүүжилтийг улсын төсөвт тусган хэрэгжүүлсэн байна | Сүхбаатар сумын үерийн хамгаалалтын далан, авто замын ус зайлуулах системийн ажлын зураг төслийг хийж, улсын төсөвт суулгуулах санал өгсөн. | 30% |
| 77 | 5 | 5. Мандал, Баянгол, Сайхан сумдын далан сувгийг шинэчлэх ажлыг эхлүүлэх | Орон нутгийн төсөв | Гүйцэтгэлийн хувь | 2021 | 2021 онд Алтанбулаг сумын далангийн засварыг хийж гүйцэтгэсэн. | Санхүүжилтийг шийдвэрлэж, үе шаттайгаар ажлыг эхлүүлсэн байна | Сэлэнгэ аймгийг хөгжүүлэх 2023 оны жилийн төлөвлөгөөнд Сүхбаатар, Мандал, Баянгол, Сайхан сумдын үерийн даланг шинэчлэх ажлыг хийхээр оруулан хөрөнгийг асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. | 90% |
| 78 | 6 | 6. Сумдын хилийн цэсийн асуудлыг шат, шатны байгууллагад уламжилж, хот төлөвлөлтийн өргөжин тэлэх боломжийг эхлүүлэх | Орхон нутгийн төсөв | Асуудал шийдвэрлэгдсэн эсэх | 2021 | Сумдын хилийн цэсийн асуудлаар холбогдох байгууллагад санал уламжилсан байна | Сумдын хилийн цэсийг өөрчлөх асуудлыг хууль тогтоомжийн дагуу байгууллагад уламжил шийдвэрлүүлсэн байна | Сумдын суурьшлын бүс буюу эдэлбэр газрын хил заагийг шинэчлэн тогтоох ажлын хүрээнд 14 сумдаас санал авч нэгтгэн газар дээр нь хэмжилт тодруулга хийж, хил заагийг шинэчлэн тогтоож зурагжуулах асуудлаар бүх сумдад ажиллаж сумын Засаг дарга болон иргэдийн Төлөөлөгчдийн хуралд танилцуулга хийн санал авах ажлыг зохион байгуулсан. Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд Орхон, Сайхан сумдын хилийн цэсийг өөрчлөх асуудлыг судлан тусгахаар гүйцэтгэгч байгууллагад санал хүргүүлсэн. | 100% |
| **ДӨРӨВ. “ЭДИЙН ЗАСАГ”** | | | | | | | | | |
| **Зорилго: Төсвийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан ил тод нээлттэй төлөвлөн хуваарилж, салбарын хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөв, санхүүгийн менежментийг сайжруулж, аймгийн эдийн засгийг жил бүр тогтвортой өсгөх бодлогыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | |
| **4.1 Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд** | | | | | | | | | |
| **Зорилт: Эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, газар тариалан, эрчимжсэн мал ахуй, аялал жуулчлал, үйлдвэрлэлийн салбарт түшиглэсэн эдийн засгийн цогцолбор бүс нутаг болно.** | | | | | | | | | |
| 79 | 1 | 1. Орон нутгийн хөгжлийн индексийг батлагдсан аргачлалын дагуу боловсруулж, сумдын түвшинг | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт | Орон нутгийн хөгжлийн индексийн үзүүлэлт | 2021 | 2016-2020 оны орон нутгийн хөгжлийн индекс тооцох мэдээллийг бүрэн | 2021 оны индексийг батлагдсан аргачлалын дагуу тооцож, мэдээллийг байршуулсан | Эдийн засаг хөгжлийн яаманд 2021 оны орон нутгийн хөгжлийн индексийг тооцох судалгааг 17 сумаас авч хүргүүлж, 2021 оны орон нутгийн хөгжлийн индексийг тооцсон, үр дүнг "Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим мэдээллийн систем"-д оруулан баталгаажуулан | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тодорхойлох | | | | байршуулсан | байна. | ажиллаж байна. | |
| 80 | 2 | 2. Олон Улсын Авто зам, төмөр замыг түшиглэн тээвэр ложистикийн төвийг байгуулах зураг төсөв ТЭЗҮ боловсруулах | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт | Зураг төсөв ТЭЗҮ | 2021 | Алтанбулаг сумын хилийн боомтын шинэчлэлийн ажлын зураг төсөвийг боловсруулагдаж байна. | Зураг төсөв ТЭЗҮ боловсруулагдсан байна. | Сүхбаатар сум доторх Авто замыг шинэчлэх, шинээр хийгдэх хатуу хучилттай авто зам, явган зам, дугуйн замын ажлын зураг, төсвийг зөвлөх үйлчилгээний "Ангад арвижих" ХХК-иар гүйцэтгүүлсэн. | 100% |
| 81 | 3 | 3. Аймгийн төвийн 50 мвт ийн дулааны цахилгаан станц боловсруулах ТЭЗҮ, зураг төсөв боловсруулахаар холбогдох байгууллагад санал уламжлах | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт | Зураг төсөв ТЭЗҮ | 2021 | Аймгийн төвийн 50 мвт ийн дулааны цахилгаан станц боловсруулах тооцоо судалгааг харъяалах яам, Засгийн газарт саналыг уламжилсан. | Зураг төсөв ТЭЗҮ боловсруулах төсөв батлагдсан байна. | Аймгийн төвийн 50 мвт-ийн дулааны цахилгаан станц барих техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд тооцоо судалгаанд шаардагдах анхдагч мэдээллээр хангах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2022 оны А/483 тоот захирамжаар байгуулан ажиллаж байна. | 70% |
| **4.2. Ухаалаг санхүүгийн бодлого** | | | | | | | | | |
| **Зорилт: Эдийн засгийн тогтвортой өсөлт өрх бүрдээ хүрсэн, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, аялал жуулчлалын салбарт түшиглэсэн эдийн засгийн цогцолбор бүс нутаг болно** | | | | | | | | | |
| 82 | 1 | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж, төсвийн байгууллагуудын шилэн дансны мэдээллийн хугацаанд нь байршуулах, түүнд тавих хяналтыг сайжруулах. | Улсын болон Орон нутгийн төсөв /10 сая/ | Шилэн дансны мэдээллийн байршуулалтын хувь | 2021 | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж, төсвийн байгууллагын шилэн данс хөтлөлт 85 хувийн гүйцэтгэлтэй байна. | Шилэн дансны байршуулалтад хагас бүтэн жилээр дотоод аудит хийж, мэдээллийн чанар, бодит байдалд хяналт тавьж, асуудлыг шийдвэрлэх. Мэдээллийн байршуулалтыг 100% хүргэх | 2022 оны жилийн эцсийн байдлаар төсвийн 191 байгууллага, ОНӨААТҮГ 20, төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэгч 98 байгууллага шилэн дансанд мэдээллээ байршуулан ажиллалаа. Шилэн дансны мэдээлэл байршуулалтын хувь 98.2 хувь болж өмнөх оноос 0.8 пунктээр нэмэгдсэн байна. Нөхөн байршуулах, хуулийн хугацаанд мэдээллээ оруулах албан шаардлагыг ОНӨААТҮГ-уудад хүргүүлэн, зөрчлийг арилгуулсан. | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 83 | 2 | 2. Хөрөнгийн Зах зээл форекс арилжааны тухай ойлголт, хэрэглээ болон блокчейн технологид суурилсан биткойны талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах | Улсын болон Орон нутгийн төсөв /1.5 сая/ | Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо | 2021 | - | Иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээг шинэлэн хэлбэрээр зохион байгуулж аймгийн нийт иргэдийн 6 хувийг хамруулсан байна. | Аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга нарт иргэдийн санхүүгийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах үүрэг өгсөн бөгөөд Сумдын Санхүүгийн албанд Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран "Татвар төлөгчийн үүрэг хариуцлага", "Санхүүгийн салбарын чиг хандлага", "Хадгаламжийн ашиг шим" сэдвээр давхардсан тоогоор 12 мянга гаруй сурагч багачууд, иргэдэд сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгч ажиллалаа. | 100% |
| 84 | 3 | 3.Шинээр томилогдсон багийн Засаг дарга нар болон сумдын Статистик хариуцсан ажилтнуудыг чадавхижуулах сургалт зохион байгуулах. | Улсын болон Орон нутгийн төсөв /1.5 сая/ | Сургалтад хамрагдсан хүний тоо | 2021 | “Ковид-19” цар тахлаас хамаарч сургалт зохион байгуулагдаагүй байна. | 57 багийн Засаг дарга, 17 сумын статистик хариуцсан ажилтнуудыг чадавхижуулснаар анхан шатны статистик мэдээний чанар дээшилнэ. | 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр аймгийн 57 багийн Засаг дарга, сумдын Статистик мэдээ хариуцсан 17 албан хаагч нарыг хамруулсан чадавхижуулах сургалтыг зохион байгуулсан. Хүн ам, өрхийн мэдээллийн сан, мал тооллогын мэдээллийн сан, нийгмийн салбарын мэдээ тайлан, хөдөө аж ахуйн салбарын мэдээ тайлан гаргах, статистик мэдээлэл, судалгаа шинжилгээ хэрхэн цуглуулах, боловсруулах, мэдээний хэрэглээ ач холбогдол сэдвээр сургалтыг зохион байгуулсан. | 100% |
| 85 | 4 | 4. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Төсвийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагын татварын баазын | Улсын болон Орон нутгийн төсөв / | Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь | 2021 | 2020 оны улсад төвлөрүүлсэн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 828.5 сая төгрөг буюу 110.5 хувь, 2021 оны 3 дугаар улирлын байдлаар 677.5 сая төгрөг байна. | 2022 онд аймагт төвлөрүүлэх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төлөвлөгөө 19.2 тэрбум төгрөг | 2022 онд Улсын бүртгэлийн газарт шинээр бүртгэгдсэн 225 татвар төлөгчийг Татварын мэдээллийн системд бүртгэн татвар төлөгчийн баазыг 4.5 хувиар нэмэгдүүлж ажилласан. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын гүйцэтгэл 15.4 тэрбум төгрөг буюу 80 хувийн гүйцэтгэлтэй байна. Том татвар төлөгч болох Болд төмөр "Ерөө гол" ХХК, "Бороо гоулд" ХХК-ны үйл ажиллагаанаас шалтгаалан тус орлого тасарсан болно. | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүртгэлийг сайжруулж, аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг бүрэн төвлөрүүлж, аймгийн төсвийн орлогын биелэлтийг хангах | | | | | | | |
| **4.3. Өрсөлдөх чадвартай Брэнд бүтээгдэхүүн** | | | | | | | | | |
| **Зорилт: Сум бүр үйлдвэрлэгч байж, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | |
| 86 | 1 | 1.“Ахуйн үйлчилгээг хөгжүүлэх” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Улс, аймаг, сумын орон нутгийн төсөв | Хэрэгжилтийн хувь | 2021 | Арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг зохион байгуулж байна | Шинээр 3 доошгүй орчин үеийн шаардлагад нийцсэн ахуйн үйлчилгээ төв байгуулагдсан байна | Шаамар сумын Дулаанхаан тосгоны халуун усны барилгыг улсын төсвийн хөрөнгөөр “Хос соёмбот өргөө” ХХК гүйцэтгэж, гадна шугам сүлжээ, угсралтын ажил дууссч, дотор шугам сүлжээ, заслын ажил хийгдэж, гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байна. Хоршоо хөгжүүлэх сангаас Сүхбаатар сумын 1 иргэд 10 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, аж ахуйн нэгж, иргэдийн хөрөнгө оруулалтаар шинээр 5 суманд 8 ахуйн үйлчилгээний цэг салбар байгуулагдаж, 15 ажлын байр шинээр бий болон, үйлчилгээний хүртээмж 5 хувиар нэмэгдлээ. Монголын Үсчин, гоо засалчдын Холбооноос Орхон аймагт зохион байгуулсан “Үндэсний аварга шалгаруулах үсчин, гоо засалч, хумс дизайн урлалын 25 дугаар их наадам”-д Сүхбаатар, Мандал сумдын 29 үсчин, гоо засалчид оролцож, “Эмэгтэй креатив хэлбэржүүлэлтийн төрөл”-д Мандал сумын “Димонд” салоны эрхлэгч Г.Цэрмаа “Алтан медаль”, “Эрэгтэй зураглалтай засалтын төрөл”-д “Варбер” салоны үсчин Н.Баяртогтох “Алтан медаль”, Сүхбаатар сумын “Эрэгтэй зураглалтай засалтын төрөл”-д Б.Анхзаяа “Мөнгөн медаль”, “Эмэгтэй креатив хэлбэржүүлэлтийн төрөл”-д Д.Батсүрэн “Мөнгөн медаль”, “Бие дээрх уран зураглалын төрөл”-д Б.Үүрийнтуяа | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | “Тусгай байр”-ны шагналуудыг хүртэж, орчин үеийн шинэ үсний засалт, нүүрэн дээр зурах технологи, хумсны урлал, үйлчилгээний ур чадварыг харилцан суралцаж, энэ жилийн үс, гоо сайхны чиг хандлага, өвөрмөц урсгалуудыг нэвтрүүлэх мэдээллийг олгосон. | |
| 87 | 2 | 2.Согтууруулах ундаа, худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам"-ын хэрэгжилтийг зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Шийдвэрлэлт ийн хувь | 2021 | Шинэчилсэн журмын төслийг боловсруулж, Иргэдийн төлөөлөлгчдийн хурлаар батлуулахаар бэлтгэл ажил хангасан. | Журмыг батлуулж хэрэгжилийг зохион байгуулсан байна. | Аймгийн Засаг даргын 2022 оны 1, 2, 3, 4 -р улиралд Аймгийн Засаг даргын А/07, А/135, А/353, А/450 тоот захирамжаар 202 аж ахуйн нэгжийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 2 жилээр сунгаж, 17 аж ахуйн нэгжид шинээр тусгай зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчил дутагдлыг тухай бүр нь арилгуулан ажиллаж байна. | 100% |
| 88 | 3 | 3."Сэлэнгэд үйлдвэрлэв”, “Сэлэнгэ ургац”, Гонгорын бумбаны тахилга”, “Цам харайх”, “Майдар эргэх”, “Монос цэцэглэх үеэр” Хараагийн баяр арга хэмжээнүүдийг зохион байгуулах | Улс, аймаг, сумын орон нутгийн төсөв | Оролцсон аж ахуйн нэгжийн тоо, борлуулалтын дүн | 2021 | "Гонгорын бумбаны тахилга” арга хэмжээ цахимаар, “Монос цэцэглэх үеэр” Хараагийн баяр, “Сэлэнгэ ургац”, “Сэлэнгийн ногоон өдрүүд” эвент арга хэмжээг зохион байгуулж, 5400 иргэдийн оролцуулсан. | 3 доошгүй арга хэмжээ зохион байгуулж, 8100 хүнийг оролцуулсан байна. | Шаамар, Сүхбаатар сумдын Засаг даргын Тамгын газар Хаврын тэргүүн сарын шинийн нэгний “Ханш нээх өдөр”, "Гонгорын бумбаны тахилга”-г зохион байгуулж, арга хэмжээнд 2000 гаруй автомашинтай 5000 гаруй иргэд оролцсон. Аймгийн төвд “ЭКСПО ЯАРМАГ”, “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл 2022” ,“Сэлэнгэ-Алтан намар 2022”, “Хөдөлмөрийн бүтээмж 2022” үзэсгэлэн худалдаануудыг зохион байгуулж, 16 сум, чөлөөт бүс, Улаанбаатар хот, Орхон, Дархан Уул аймаг, Буриад улсын 318 аж ахуйн нэгж, иргэд 218 гаруй нэр төрлийн 457.3 сая төгрөгний борлуулалт хийж, үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн борлуулалтыг нэмэгдүүлэх, ард иргэдийн хэрэгцээг хямд үнэтэй, чанартай, эрүүл экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангаж, аж ахуйн нэгж, иргэдийн нөр их хөдөлмөрийн үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, хэрэглэгчдэд үзүүлж буй үйлчилгээг сурталчлах, худалдааны түншлэл тогтоох, харилцан туршлага солилцох, үндэсний үйлдвэрлэлээ дэмжсэн арга хэмжээ болсон. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 89 | 4 | 4. Орчин үеийн шийдэл бүхий худалдааа үйлчилгээний төвийг ашиглалтад оруулах | Хувийн хөрөнгө оруулалт | Худалдаа үйлчилгээний төвийг байгуулсан эсэх | 2021 | Өөрийн хөрөнгө оруулалтаар "Цахим ертөнц" ХХК худалдаа үйлчилгээний төвийг байгуулахаар ажиллаж, ажлын явц 30 хувьтай явагдаж байна. | Аймгийн төвд худалдаа үйлчилгээний төв байгуулагдсан байна. | Сүхбаатар суманд хувийн хэвшлийн санаачлагыг дэмжин орчин шаардлага нийцсэн 3 давхар худалдаа, үйлчилгээний төвийг ашиглалтад оруулсан. | 100% |
| 90 | 5 | 5. Сумдын онцлох брэнд бүтээгдэхүүнээр бэлгийн багц гаргах ажлыг зохион байгуулах | Улс, аймаг, сумын орон нутгийн төсөв, Хувийн хөрөнгө оруулалт | Бэлгийн багцтай болсон эсэх | 2021 | “Сэлэнгийн брэнд” гар урлал, бэлэг дурсгалын бүтээлийн уралдаан, “Сэлэнгэ ургац 2021" үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан | 2 доошгүй бэлгийн багцыг зах зээлд гаргаж ажилласан байна. | “Брэнд” бүтээгдэхүүний бэлгийн багц”-ыг бий болгох, дотооддоо үйлдвэрлэсэн, орон нутгийн онцлог, дүр төрхийг илэрхийлсэн, чанар стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, аймагт аялан ирсэн зочид, аялагчдад гарын бэлэг болгон дурсгах, үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд бодлогоор дэмжих зорилгоор Сумын онцлох брэнд бүтээгдэхүүнээр бэлгийн багц гаргах уралдаан”-ыг 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр хүртэл аймаг, сум, багийн хэмжээнд зохион байгуулахаар захирамж, ажлын хэсэг, уралдааны удирдамжийг боловсруулсан боловч “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн 15.2.3 дахь заалт сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, холбогдох бусад зардлыг хэмнэхээр заасан тул хийгдэх боломжгүй болсон. | 90% |
| **ТАВ. ЗАСАГЛАЛ** | | | | | | | | | |
| **Зорилго: Нутгийн захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн албыг бэхжүүлж, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээг төлөвшүүлэн, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлийг бүх талаар дэмжсэн хүний эрхийг дээдэлсэн авлигагүй, ХАРИУЦЛАГАТАЙ, ТЭГШ, НЭЭЛТТЭЙ төрийн үйлчилгээ бүхий аймаг байна.** | | | | | | | | | |
| **5.1. Ухаалаг бүтэц** | | | | | | | | | |
| **Зорилт: Нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, оролцоог зохистой хангасан, иргэдээ сонсдо, хувийн хэвшүилтэйгээ хамтарч ажилладаг тогтолцоог бэхжүүлнэ.** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 91 | 1 | 1. Нутгийн захиргааны байгууллагуудад чиг үүргийн шинжилгээ хийж ажил, үүргийн давхцлыг арилгах | Тухайн байгууллагын төсөв | Давхацсан чиг үүргийн тоо | 2021 | Аймгийн ЗДТГ, аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Боловсролын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар, Орон нутгийн өмчийн газар, Санхүүгийн хяналт аудитын албад чиг үүргийн шинжилгээг хийсэн. | Сумын ЗДТГ, тосгоны захирагчийн албаны бүтэц орон тоог шинэчлэх санал боловсруулсан байна. | Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 40 дүгээр тогтоолоор баталсан сумдын ЗДТГ-ын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод чиг үүргийн шинжилгээ хийж, өөрчлөлт оруулах саналыг нэгтгэн аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 02/845 тоот албан бичгээр Төрийн албаны Зөвлөлд хүргүүлсэн. Үүнд: Сумдад дэд бүтэц хариуцсан, худалдаа үйлчилгээ, төрийн захиргаа, дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалуудыг шинэчлэн баталж өгөх. Мөн дэд бүтэц хөгжсөн, хүн ам ихтэй Мандал, Сайхан, Сүхбаатар суманд эдийн засагч статистикч, байгалийн дагалдах баялаг ихтэй сумдад байгаль орчны хяналтын улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг батлуулахаар саналыг тус тус хүргүүлсэн. Одоогоор шинэчлэн батлагдсан Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн дагуу сум орон нутгийнхаа онцлогт тохируулан сумдын ЗДТГ-ын дарга нар бүтцээ батлан ажиллаж байна. | 90% |
| 92 | 2 | 2. Төрийн албан хэрэг хөтлөлтийг кирил болон үндэсний бичгээр хослуулан явуулах ажлыг эхлүүлж бүх шатны байгууллагуудад сургалт зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 2021 | Төрийн албан хэрэг хөтлөлтийг кирил бичгээр явуулж байна | Албан хаагчдын төрийн албан хэрэг хөтлөлтийн болон үндэсний бичгийн мэдлэг чадвар дээшилнэ | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлж, 2025 оноос төрийн албан хэрэг хөтлөлтийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг хангах үүднээс үндэсний бичиг үсгийн баярын өдрийг тохиолдуулан “Үндэсний бичигтэн 2022-2024” хөдөлгөөний нээлтийг зохион байгуулж, аймгийн төв Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагын албан хаагчдын 420 төлөөлөл оролцлоо. МУБИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн их сургуулийн Монгол хэлний тэнхимийн багш, хэл шинжлэлийн ухааны доктор, профессор Д.Ганболд “Үндэсний бичиг үсэг-тусгаар тогтнолын баталгаа” сэдэвт сургалтыг төр, төсвийн байгууллагын албан хаагчдад цахимаар зохион байгуулсан. Төрийн албаны | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | зөвлөлөөс Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх хэлний бодлогын зөвлөлтэй хамтран “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ын талаар зохион байгуулсан сургалтад аймгийн хэмжээнд төрийн бүх шатны байгууллагын 3200 гаруй албан хаагчдыг хамруулсан. | |
| 93 | 3 | 3.Иргэдийн өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх зарчмыг баримтлан “ТАНЫГ СОНСОЁ” арга хэмжээг “ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ӨДӨР”-тэй хамтатган зохион байгуулах | Тухайн байгууллагын төсөв | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2021 | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | Санал хүсэлт, өргөдөл гомдол шуурхай шийдвэрлэгдэнэ. | Аймгийн хэмжээнд төрийн байгууллага, албан тушаалтанд 2022 онд нийт 3522 иргэн хандаж санал, хүсэлт, өргөдөл, гомдол гаргаснаас 3441 иргэний өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн нь 97.7 хувийн үзүүлэлттэй байна. Нийт ирсэн өргөдөл, гомдлыг 2021 онтой харьцуулахад 1949 буюу 35.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд бүх шатны байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг дунджаар 14 хоногт хүргэлээ. “Таныг сонсъё” арга хэмжээг “Төлөөлөгчдийн өдөр”-тэй хамтатган Зүүнбүрэн суманд зохион байгуулж 400 гаруй иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж ажилласан. Монгол Улсын Ерөнхий Сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 214 дүгээр захирамжийн дагуу Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд судлан үзэж, шуурхай шийдвэрлэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/526 тоот захирамжаар байгуулан аймгийн хэмжээнд 12 дугаар сарын 09-24-ний өдрүүдэд шийдвэрлэгдээгүй байсан 183 өргөдөл, гомдлыг шийдвэрлэн хариуг холбогдох иргэдэд хүргүүлэн ажилласан. Улсын хэмжээнд зохион байгуулсан уг арга хэмжээнд тандалт дуудлага хийгдэхэд асуудал үүсгээгүй, шуурхай шийдвэрлэж ажилласан 5 аймгийн нэгээр шалгарсан тул Засгийн газрын Хэрэг | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | эрхлэх газраас талархал ирүүлсэн. | |
| 94 | 4 | 4.Гадаад харилцааны хамтын ажиллагааны шинэ түншлэлийг нэмэгдүүлэх | Орон нутгийн төсөв | Шинэ түншлэлийн тоо | 2021 | Цар тахалтай холбогдуулан гадаад арга хэмжээ хийошлогдсон. | Гадаад хамтын ажиллагааны үр нөлөө нэмэгдэнэ. | 2022 онд БНСУ-ын Дангжин хотын Засаг дарга У Сон Хуан, ИТХ-ын дарга Ким Дог Жү тэргүүтэй тус хотын төлөөлөгчид аймгийн Засаг даргатай хамтран ажиллах хэлэлцээрт гарын үсэг зурлаа. Энэхүү хэлэлцээрээр Сэлэнгэ аймаг болон Дангжин хот хоорондын түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж газар тариалан, эдийн засаг, нийгэм, соёл, хүмүүнлэгийн салбар, чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцож, БНСУ-ын Дангжин хотод Сэлэнгэ аймгаас улирлын гэрээт ажилтан нийлүүлэх гэрээний төсөлд гарын үсэг зурлаа. Мөн БНСУ-ын Үньпён дүүрэгтэй салбар бүрийн боловсон хүчин, ажилтан албан хаагчдаа сургаж мэрэгшүүлэхэд амжилттай хамтран ажиллахаар санамж бичиг байгуулсан. “Гадаад харилцааг эдийн засагжуулах нь” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж БНБУ-ын тэргүүн Алексей Самбуевич Цыденовтой 2 удаагийн хэлэлцээр хийж, боловсрол, соёл, эрүүл мэнд, худалдаа, эдийн засаг, хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллахаар тохиролцсон бөгөөд ОХУ-ын БНБУ-ын Боловсрол, шинжлэх ухааны сайдын үүргийг орлон гүйцэтгэгч Поздняков Валерий Анатольеивич тэргүүтэй боловсролын байгууллагын төлөөлөгчид албан айлчлал хийж, уулзалт зохион байгууллаа. Аймаг, орон нутгийн зүгээс аймагтаа хүүхэд, залуучуудын орос хэл сурах идэвхийг өрнүүлж Буриад улсад сурах хүсэлтэй оюутнуудад хөнгөлөлт үзүүлэх, орос хэлний багш нарыг бэлтгэх, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дадлагажуулах, хилийн ойр бүс нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх, хавдарын цөмийн эмчилгээний төвтэй хамтран хамтран ажиллаж байна. | |
| **5.2. Цахим засаглал** | | | | | | | | | |
| **Зорилт: Төрийн үйлчилгээний цахим шилжилтийг үе шаттай хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 95 | 1 | Төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн систем “ERP.E-Mongolia.mn” цогц системийг аймгийн хэмжээнд нэвтрүүлэх | Орон нутгийн төсөв | Нэвтрүүлсэн байгууллагын тоо | 2021 | Аймгийн ЗДТГ-ын албан хаагчид, сумын ЗДТГ, тосгодын захирагчийн албад, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 23, ОНӨААТҮГ-ууд зарим төсөвт байгууллагуудын хүний нөөц болон архив, бичиг хэргийн ажилтнуудын 123 эрхээр Эйбл софт ХХК-ний системийг 2015 оноос ашиглаж байна. | Аймгийн хэмжээнд ажиллаж байгаа 209 байгууллагын 6210 албан хаагчид нэгдсэн системийг хэрэглэх боломжтой болно. | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны харьяа И-Монгол академитай хамтран аймгийн хэмжээнд систем нэвтрүүлж эрх олгох 2 удаагийн цахим сургалтыг зохион байгуулсан. Аймгийн нийт төр, төсвийн 210 байгууллагад нэвтрүүлэхээс 148 байгууллагатай гэрээ байгуулан нэвтрүүлэх эрхийг олгоод байна. Үлдсэн байгууллагуудыг гэрээ байгуулж, эрх олгох ажлыг зохион байгуулж байна. | 70% |
| 96 | 2 | E-Mongolia цахим үйлчилгээний талаар сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд цахим үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх. | Орон нутгийн төсөв | Цахим үйлчилгээ авсан иргэдийн тоо | 2021 | Төрийн үйлчилгээг операторийн горимоор үзүүлэх E-Mongolia цахим үйлчилгээг 17 суманд нэвтрүүлсэн. | Иргэд төрийн үйлчилгээг цахимаар болон операторийн горимоор авдаг болсноор цаг хугацаа, эдийн засгийн хэмнэлт бий болно. | Засгийн газрын “Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 2019 оны 149 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн үйлчилгээг операторын горимоор цахимжуулж, бүх сумддаа нэвтрүүлсэн 5 аймгийн нэг болсон. ЦХХХЯ-ны харьяа И-Монгол академи УТҮГ-тай хамтран 2 шатлалт үйлчилгээг аймгийн хэмжээнд 15 байгууллагын 73 нэр төрлийн 269 үйлчилгээг нэвтрүүлэх системийн сургалт болон эрх олгох арга хэмжээг зохион байгуулсан. 2022 оны жилийн эцсийн байдлаар сарын байдлаар давхардсан | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | тоогоор нийт 12310 иргэн үйлчилгээ авсан байна. | |
| **5.3. Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба** | | | | | | | | | |
| **Зорилт: Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, чадахуйн зарчимд тулгуурласан ухаалаг, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлнэ.** | | | | | | | | | |
| 97 | 1 | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг зохион байгуулж, зөвлөн туслах үйлчилгээг ААН байгууллагуудад үзүүлэх | Орон нутгийн төсөв | Зөрчлийн тоо | 2021 | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг аймгийн хэмжээнд 600 гаруй ААН байгууллагад үзүүлсэн. | Илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авч, үйл ажиллагаа стандартын шаардлагад нийцсэн байна. | 2022 онд төлөвлөгөөт бус 53, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт 213, зөвлөн туслах үйлчилгээг 39 аж ахуйн нэгжид үзүүлсэн бөгөөд зөрчлийн тоог өмнөх оноос бууруулж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажилласан. | 70% |
| 98 | 2 | 2. Цахилгааны 3 фазын тоолуурыг шалган баталгаажуулах иж бүрэн эталон төхөөрөмжийг шийдвэрлэх | Орон нутгийн төсөв | Шийдвэрлэсэн эсэх | 2021 | Аймгийн хэмжээнд 3 фазын тоолуурыг Дархан-Уул аймагт шалган баталгаажуулдаг. | Эталон хэмжүүртэй болсноор орон нутгийнхаа иргэд, ААН-ийн тоолуурыг баталгаажуулдаг болно. | Цахилгааны 3 фазын тоолуур орон нутагтаа шалган баталгаажуулах иж бүрэн эталон төхөөрөмжийг шийдвэрлүүлэхээр саналаа уламжилсан боловч эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан төсөв хөрөнгө шийдвэрлэх боломжгүй болсон. | 0% |
| 99 | 3 | 3. ОБЕГ-тай хамтран аймгийн гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Хамрагдсан байгууллагын тоо | 2021 | Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль 2012 оноос хойш хийгдээгүй байна. | Аймгийн хэмжээнд төр, хувийн хэвшил, ААН байгууллага иргэдийн гамшгийн талаарх мэдлэг нэмэгдэнэ. | Монгол Улсын Шадар сайдтай 2022 онд байгуулсан хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн А/115 дугаар тушаалаар томилогдсон, сургуулийн удирдагч, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, бригадын генерал Б.Ууганбаяраар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн Сэлэнгэ аймагт Иж бүрэн сургуулийг 2022 оны 6 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд зохион байгуулж “Дүүрэн онц” үнэлгээтэй дүгнэгдсэн. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газар, нийслэлийн Онцгой байдлын газар, Монголын Улаан загалмай нийгэмлэг | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | зэрэг байгууллагуудаас бүрдсэн 5 ажлын хэсгүүдийг байгуулан өргөн хүрээтэйгээр зохион байгуулж Сэлэнгэ аймгийн 17 сум, 6 тосгоны нийт 8742 иргэдийг хамруулж, гамшгаас хамгаалах сургалтыг онолын 60 хувийн үр дүн, дадлагын 40 хувийн үр дүнтэйгээр зохион байгуулсан. | |
| 100 | 4 | 4.Дадлага сургууль хийх сургалтын цогцолбор төвийг Алтанбулаг сумын “Гүн нуур”-ын эрэгт байгуулах | Орон нутгийн төсөв 120 сая төгрөг | Байгуулсан эсэх | 2021 | Аймгийн хэмжээнд дадлага сургууль хийх сургалтын цогцолбор төв байхгүй байна. | Онцгой байдлын байгууллагын усчин аврагчдын гүний усны сургалтын төвтэй болсноор аврагчдын ур чадвар нэмэгдэнэ. | Тус сургалтын төвийг нийт 350 сая төгрөгийн төсвөөр байгуулахаар төлөвлөөд байгаа бөгөөд Онцгой байдлын ерөнхий газарт хүсэлт уламжлан 2022 оны “Жагсаалт батлах тухай” А/23 дугаар тушаал, “Үүрэг хүргүүлэх тухай” 1/280 дугаар албан бичгээр 150 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн. Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу аймгаас олгогдох 200 сая төгрөг хойшлогдсон. Онцгой байдлын ерөнхий газраас олгогдсон төсөвт багтаан Онцгой байдлын байгууллагын усчин-аврагчдын гүний усны дадлага, сургууль хийх сургалтын цогцолбор төвийг Алтанбулаг сумын “Гүн нуур”-ыг түшиглэн байгуулахаар бэлтгэл ажлыг ханган дэд бүтцийн ажлуудыг хийгээд байна. | 70% |
| 101 | 5 | 5.Цагааннуур суманд эрэн хайх, аврах салбар, Ерөө сумын Бугант тосгонд эрэн хайх, аврах бүлэг байгуулах саналыг холбогдох байгууллагад уламжлах | Орон нутгийн төсөв | Уламжилсан эсэх | 2021 | Аврах салбар болон эрэн хайх бүлэг зайлшгүй шаардлагатай байна. | Сэлэнгэ бүсийн төв болон Бугант тосгонд эрэн хайх, аврах салбар, бүлэг байгуулах саналыг хүргүүлсэн байна. | Цагааннуур суманд эрэн хайх, аврах салбар, Баянгол суманд эрэн хайх, аврах бүлэг байгуулахад шаардагдах төсөв, барилга, газрын асуудлыг сум орон нутгаар шийдвэрлүүлж, эрэн хайх, аврах бүлэг, салбарын байгуулахад шаардагдах норм стандарт дагуу саналын төслийг боловсруулж Онцгой байдлын ерөнхий газар болон холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн. | 100% |
| 102 | 6 | 6.Хүдэр, Түшиг, Цагааннуур сумд, Бугант тосгонд гал унтраах тусгай зориулалтын автомашин шийдвэрлүүлэх | Орон нутгийн төсөв 240 сая төгрөг | Сумдын тоо | 2021 | Аймгийн хэмжээнд гал унтраах 4 ангид нийт 8 автомашин байна | Гамшгаас хамгаалах албадын үйл ажиллагааг сайжирна. | Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын гамшгаас хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд Сөүл хотын Гал, гамшгийн удирдах газар, Ази, Африкийн хөгжлийн тусламжийн сан зэрэг байгууллагуудаас манай аймгийн Шаамар, Цагааннуур, Хүдэр, Түшиг | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сумдын гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, сайн дурын албадад буцалтгүй тусламжаар гал унтраах зориулалтын 4 автомашиныг шийдвэрлүүлсэн. Тус авто машиныг ашиглах сумдын холбогдох албан хаагч нарыг сургалтад хамруулах, дээрх автомашинуудыг нэмэгдсэн өртгийн албан татвар болон холбогдох бусад хураамжаас чөлөөлүүлэх ажлуудыг зохион байгуулж, хүлээн авахад шаардагдах 200.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр шийдвэрлүүлж автомашинуудыг сумдад хүлээлгэн өгсөн. | |
| 103 | 7 | 7. Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтыг зохион байгуулж, төрийн албаны нөөцийг бүрдүүлэх, төрийн байгууллагын сул тоог нөхөх арга хэмжээг хэрэгжүүлэх | Төрийн албаны Салбар зөвлөлийн төсөв | Нөөцөд бүртгэгдсэн иргэдийн тоо, нөхөгдсөн сул орон тоо | 2021 | 2021 онд 2 удаагийн ерөнхий шалгалт зохион байгуулж, төрийн албаны 143 иргэн нөөцөд бүртгэгдсэн. Мөн төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтыг 1, төрийн захиргааны албан тушаалын тусгай шалгалтыг удаа явуулж, төрийн захиргааны 65, Төрийн үйлчилгээний 10 сул орон тоог нөхөх арга хэмжээ авсан. | Төрийн албаны тасралтгүй байдлыг хангаж ажилласан байна. | 2022 онд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албадын төрийн захиргааны удирдах ба гүйцэтгэх албан тушаалын болон төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалын нийт 305 /давхардсан тоогоор/ сул орон тооны захиалгыг хүргүүлж, 10 удаагийн тусгай шалгалтыг зохион байгуулж, Төрийн захиргааны удирдах албан тушаалын 17, гүйцэтгэх албан тушаал /дэс түшмэл, туслах түшмэл/-ын 63, Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийн 11 сул орон тоог нөхөх арга хэмжээг авлаа | 100% |
| 5.4 Ухаалаг засаглал | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр нөлөөг дээшлүүлэх, нутгийн захиргааны байгууллагуудын ажлын уялдааг хангах, үйл ажиллагааг үнэлж, дүгнэх зорилго бүхий цахим мэдээллийн санг ашиглалтад оруулж, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад чиг үүргийн шинжилгээ хийж, ажил үүргийг оновчтой болгон нутгийн захиргааны байгууллагуудын менежментийг сайжруулна. | | | | | | | | | |
| 104 | 1 | 1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх | - | Хяналт-шинжилгээ хийсэн дэд хөтөлбөрүүдийн тоо тогтоолд заасан хугацаа | 2021 | Аймгийн 2 дэд хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж гүйцэтгэсэн. | Аймгийн 4 дэд хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тооцсон байна. | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хуралдаанд танилцуулах Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2021 оны төлөвлөгөөний биелэлт, “Сүрьеэгүй Сэлэнгэ” аймгийн хөтөлбөрийн хэрэгжилт, “Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж” арга хэмжээний хэрэгжилтийн тайланд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох хэлтэс, агентлагийг зөвлөгөө дэмжлэгээр хангасан. | 70% |
| 105 | 2 | 2. Аймгийн ИТХ-аас байгуулагдсан 8 ОНӨААТҮГ-уудад дотоод аудит хийж үр дүнг тооцох | Орон нутгийн төсөв | Дотоод аудитад хамрагдсан байгууллагын тоо | 2021 | Дотоод аудит хийх удирдамжийг боловсруулж бэлтгэл ажлыг хангасан | ОНӨААТҮГ-уудад дотоод аудит хийсэн байна. | “Цэнгэг Ус”, “Цант-Орхон”, “Гавшгай-Ус”, “Сэлэнгэ-Энерго”, “Цөм сүрэг”, “Барилга захиалагч”, “Сэлэнгэ Орон сууц” зэрэг 7 ОНӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу шинжилгээ, дотоод аудит хийж, зөвлөмж, албан шаардлагуудыг холбогдох газруудад хүргүүлэн ажилласан. Дотоод аудитаар орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд нь их хэмжээний өр үүссэн, хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл бэрхшээл учирч байгаа нь нийгмийн суурь үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгжид хүргэхэд томоохон хүндрэл үүсгэж байна. Санхүүгийн нөхцөл байдлыг сайжруулахад улсын төсөв болон орон нутгийн төсвөөс зайлшгүй дэмжлэг туслалцаа хэрэгтэй болож байгаа бөгөөд аудитын дүгнэлт, өвөлжилтийн нөхцөл байдлаас шалтгаалан “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-т аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 92 тоот тогтоолоор дэмжлэг үзүүлэн хэвийн үйл ажиллагааг хангасан. | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 106 | 3 | 3. Сумдад зөвлөн туслах ажлын хэсэг (баг) ажиллуулж хяналт-шинжилгээ, үнэлгээний сургалтыг бүсчлэн зохион байгуулж үр дүнг тооцох | Орон нутгийн төсөв | Сургалтад хамрагдсан төрийн албан хаагчийн тоо | 2021 | 24 агентлаг, 17 сум, 6 тосгонд цахим хэлбэрээр 2 удаа сургалт зохион байгуулсан. | Бүсчилсэн сургалтыг зохион байгуулж хяналт-шинжилгээ үнэлгээ, хариуцсан 100 төрийн албан хаагчдыг хамруулсан байна. | Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны 1, 2 дугаар сард аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга нараар ахлуулсан ажлын хэсэг сумдын 2021 оны үйл ажиллагааны үр дүн, мөн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01, 2018 оны 258, аймгийн Засаг даргын 2016 оны 05 тоот сахилга хариуцлагатай холбоотой шийдвэрүүдийн хэрэгжилт, аймаг, сумын онцгой комиссоос гаргасан шийдвэрийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын ажлуудыг газар дээр нь шалгах зорилгоор нийт сум, тосгодод зөвлөн туслах, хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулж, ажлын хэсгийн дүгнэлтүүдийг аймгийн удирдлагуудад танилцуулсан. Сумдад ажилласан ажлын хэсгүүд сумдын Засаг даргын Тамгын газрын тайлан, мэдээ хариуцсан мэргэжилтнүүд болон төсвийн байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудад анхан шатны Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйн сургалтыг зохион байгуулсан. | 90% |
| 107 | 4 | 4. Багийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, Сүхбаатар сумын Салхит 3-р багт багийн байр барих, Сайхан сумын багийн байранд засвар хийх ажилд бодлогын дэмжлэг үзүүлэх | Сайхан сумын багийн байр 28,000.0 Сүхбаатар сумын 3-р багийн байр 360,718.7 | Батлагдсан төсөв гэрээнд заагдсан хугацаа | 2021 | Сайхан сумын багийн байранд иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд хүндрэлтэй болсон, Сүхбаатар сумын 3-р багийн байргүйн улмаас биеийн тамир спортын газарт үйл ажиллагаа явуулдаг. | Батлагдсан төсөв гэрээнд заагдсан хугацаанд ашиглалтад оруулсан байна. | Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар сумын 3-р багт багийн байр барих зориулалтаар 650.0 сая төгрөгийг тусгаж, шийдвэрлэсэн боловч сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас газрын асуудал болон холбогдох бусад асуудлыг шийдвэрлээгүйн улмаас хөрөнгийг татуулсан болно. Сайхан сумын Засаг даргын Тамгын газар нь багийн Засаг даргын албан өрөөний зориулалтаар сумын Засаг даргын Тамгын газрын залгаа өргөтгөлийг худалдан авч, 15.0 сая төгрөгөөр аж ахуйн аргаар засвар үйлчилгээ хийн багийн байрны засварын явц 50 хувьтай байна. 2023 оны аймгийн төсөвт тус багийн байрыг засварлаж дуусгахаар 28.0 сая төгрөгийг батлуулаад байна. | 0% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 108 | 5 | 5. "Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба" байгуулж төрийн байгууллагын ажил үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх | Орон нутгийн төсөв | Сурталчилсан мэдээлэл, мэдээлэл хүргэсэн иргэдийн тоо хэвлэл мэдээллийн албаны зардлын хэмжээ | 2021 | Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдээр дамжуулж мэдээ мэдээллийг тогтмол хүргэдэг. | Нийт хүн амын 70 орчим хувьд мэдээлэл хүргэсэн байна. | Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба”-ыг байгуулах зорилтын хүрээнд энэ оны 9 дүгээр сараас эхлэн төрийн ажил үйлчилгээг иргэд олон нийтэд хүртээмжтэйгээр хүргэж сурталчлах зорилгын дор аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ийн дэргэд хэвлэл мэдээллийн багийг ажиллуулж эхлээд байна. Аймгийн ЗДТГ-ын бүтэц бүрэлдэхүүнд шинээр 3 хүн авч багийг бүрдүүллээ. Хэвлэлийн багийн тоног төхөөрөмжийн зардалд 19.5 сая, цалинд 10.0 сая, тавилга эд хогшилд 9.8 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Тус баг уламжлалт зураг текст бүхий мэдээллийн зэрэгцээ өнөөгийн гол чиг хандлага болох видео хэлбэрт мэдээллийг голлон гүйцэтгэн эхлээд байна. Цаашид мэдээ мэдээллийн зэрэгцээ шторк, нэвтрүүлэг, баримтат кино, шууд дамжуулалт зэрэг мэдээллийн төрөл хэлбэрүүдээр ажиллаж мэдээллийг олон нийтэд хүргэн ажиллаж байна. | 90% |
| 109 | 6 | 6. Төрийн байгууллагын ажил үйлчилгээг цаасан суурьтай болон цахим сэтгүүлээр нийтэд сурталчилах | Орон нутгийн төсөв 240 сая төгрөг | Хэвлэсэн сэтгүүлийн тоо | 2021 | 2021 онд 2000 ширхэг сэтгүүл хэвлэж иргэдэд хүргэсэн. | 4000 ширхэг сэтгүүл хэвлэж иргэдэд хүргэсэн байна. | Төрийн ажил үйлчилгээний мэдээ мэдээлэл бүхий “Өргөн Сэлэнгэ” сэтгүүлийн 1 удаагийн дугаарыг 1000 ширхэгээр бэлтгэн гаргаж иргэд олон нийтэд сурталчиллаа. Сэтгүүл А4 хэмжээ, 100 нүүртэйгээр бэлтгэгдсэн бөгөөд нийтдээ мэдээ мэдээлэл 170, ярилцлага 2, танин мэдэхүйн мэдээ мэдээлэл 1, цаг агаар, зөвлөгөө 2, зураг 325 багтлаа. Сэтгүүлийн хэвлэлтэд 8.5 сая төгрөгийг зарцуулсан. Хамтын ажиллагаатай “Сэлэнгийн мэдээ” сонины дугаар бүрт “Сэлэнгэ тойм” тогтмол буланг ажиллуулж, төр захиргааны мэдээ мэдээллийг тоймлон 12 удаагийн дугаарт /12000 ширхэг/ нийтдээ 120 гаруй удаагийн мэдээ мэдээлэл, ярилцлагыг гаргаж, иргэд олон нийтийг төр захиргаанаас гаргаж байгаа шийдвэр, мэдээллээр ханган хамтарч ажиллалаа. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 110 | 7 | 7. Төсөл хөлбөрөөр хэрэгжиж буй арга хэмжээнүүдийн үр нөлөөнд дотоод аудит хийх замаар эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ. | Орон нутгийн төсөв | Орон нутгийн иргэдийн эдийн засгийн болон нийгмийн хүртээмжийг сайжруулах | 2021 | 32 аж ахуй нэгж иргэнд 273 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. | Аж ахуй нэгж иргэдийн орлого нэмэгдсэн байна. | Аймгийн Засаг дарга ЗДТГ-тай хамтран ажиллаж байгаа томоохон төсөл хөтөлбөрийн газруудын үйл ажиллагаа, төсөлд хамрагдсан газар нутаг, хүн амын судалгааг гаргасан. Төсөл хөтөлбөрүүдийн зүгээс 12 сум, 34 хоршоо, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд дэмжлэг үзүүлж ажилласан. | 90% |
| 111 | 8 | 8. Олон Улсын болон төсөл, хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран ажиллах, үйл ажиллагааг өргөжүүлж, уламжлалт харилцааг бэхжүүлэн шинэ түншлэлийг нэмэгдүүлнэ. | Орон нутгийн төсөв | Үр дүнтэй урт хугацааны шинэ түншлэлийг нэмэгдүүлэх | 2021 | Аймгийн хэмжээнд олон улсын 6 төсөл хөтөлбөр хэрэгжсэн. | Аймгийн хэмжээнд шинээр олон улсын 2 төсөл хөтөлбөр хэрэгжсэн байна. | Аймгийн Засаг дарга, ЗДТГ-аас АДРА ОУБ, ГОУХА-ны нийгэмлэг, Европын холбооны STREAM төсөл, Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Сэлэнгэ Нэгдсэн хөтөлбөр, “Хөгжлийн Шийдэл” ТББ-ын BEST хөтөлбөр, JICA, Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлаг зэрэг Олон Улсын төсөл, хөтөлбөрийн газруудтай амжилттай хамтран ажиллалаа. Шинээр Азийн хөгжлийн банкны Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг төслийг хэрэгжүүлж түншлэлийн харилцаагаа нэмэгдүүлэхээр ажиллаж байна. | 100% |
| **5.5.Хүний эрхийг дээдэлсэн нийгэм** | | | | | | | | | |
| **Зорилт: Бүх нийтэд хүний эрхийн болон эрх зүйн боловсрол олгох, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, олон талт арга хэмжээг зохион байгуулна.** | | | | | | | | | |
| 112 | 1 | 1. “Иргэн таны хүний эрхийн боловсрол”-д арга хэмжээг төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх | Улсын болон Орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр | Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо | 2021 | Хүний эрхийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор “Таны хүний эрхийн боловсролд” цахим нийтлэлийг 10 удаа цувралаар гарган олон нийтэд хүргэн ажилласан. | “Иргэн таны хүний эрхийн боловсролд” арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хүний эрхийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх мэдээллийг нийт хүргэсэн байна | "Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр сумдын Засаг дарга, тосгодын захирагч нарт “Жендэр ба хүний эрх” сэдэвт сургалтыг зохион байгуулж, 60 албан тушаалтныг хамруулсан. Хүний эрхийн үндэсний Комиссын орон нутаг дахь ахлах шинжээчтэй хамтран Баруунбүрэн, Сант, Орхон, Орхонтуул, Шаамар, Алтанбулаг сумдад Хүний эрхийн хууль тогтоомжийн сургалтыг зохион байгуулж, 170 иргэд, төрийн албан хаагчийг хамруулсан. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 113 | 2 | 2. Аймаг, сумдын Засаг дарга нарын зайлшгүй батлуулах хэм хэмжээний актыг батлан гаргаж улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах | - | Бүртгэгдсэн хэм хэмжээний актын тоо | 2021 | Улсын нэгдсэн тоо бүртгэлд 2 хэм хэмжээний акт бүртгэгдсэн. | Хэм хэмжээний актыг батлан гаргаж, улсын нэгдсэн санд бүртгүүлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн байна. | “Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэл”-д аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 29 тогтоол, аймгийн Засаг даргын 2 захирамж бүртгэгдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй актын тулгалт судалгааг жил бүр хийж Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн. 2022 онд газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх газрын зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утгыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоохоор хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Газрын үнэлгээний бүсчлэл, газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолуудыг хүчингүй болгож, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, legalinfo.mn цахим системээс хасуулах ажлыг зохион байгуулсан. | 100% |
| 114 | 3 | 3. Шинээр батлагдсан хууль тогтоомжуудаар аймгийн хэмжээнд сургалт, сурталчилгааг зохион байгуулж, сум, агентлагийн холбогдох мэргэжилтнүүдийг чадавхжуулах | Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр | Төлөвлөгөө, сургалт, сурталчилгааны тоо | 2021 | Хууль эрх зүйн албан бус сургалт сурталчилгааг 23721 | Шинээр батлагдсан хууль тогтоомжийн сургалтыг 17 сум, 6 тосгон, 23 агентлагт зохион байгуулсан байна. | 2022 оны 01 сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн Хөдөлмөрийн тухай хуулиар, 2022 оны 05 сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”, “Цахим гарын үсгийн тухай хууль”, “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-иар Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран цахим сургалт зохион байгуулж 24 агентлаг 17 сум 6 тосгоны нийт 210 албан хаагчийг хамруулсан. “Авлигын хор хөнөөл”, “Төрийн албаны тухай хууль”, “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” зэрэг хууль тогтоомжоор 17 сум, 6 тосгон, аймгийн төвийн 6 сургууль, 8 цэцэрлэгт сургалт зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын 2022 оны “Захиргааны шийдвэр хянах, хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах төлөвлөгөө, хуваарь | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | батлах тухай" А/40 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 720 удаагийн сургалтаар 38890 иргэд, төрийн албан хаагчдад хууль, эрх зүйн сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгууллаа. | |
| 115 | 4 | 4. Хууль зүйн зөвлөгөө үйлчилгээ авах, хэрэгцээ, боломжийг тодорхойлох судалгааг хийж, анхан шатны хууль зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх | Орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр | -Судалгаанд оролцогчдын тоо -хууль зүйн туслалцаа авсан иргэдийн тоо | 2021 | Судалгаа хийгдээгүй | 17 сум, 6 тосгонд судалгаа авах ажлыг зохион байгуулсан байна. | 2022 оны 05 дугаар сарын 01-нд "Хуульчийн Про Боно өдөр-2022" өдөрлөг арга хэмжээг Партизаны талбайд зохион байгууллаа. Өдөрлөгт Монголын өмгөөлөгчдийн холбооны Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл, аймгийн Шүүх, Прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газар, Цагдаагийн газар, Гадаадын иргэн, харьяатын хойд бүс дэх газар, ХЭҮК, аймгийн Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар зэрэг 20 орчим байгууллага оролцож, үйл ажиллагаагаа сурталчлан, зөвлөгөө мэдээллээр иргэдэд үйлчилгээ үзүүлсэн. | 50% |
| **5.6.Авлигагүй засаглал** | | | | | | | | | |
| **Зорилт: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг нийтэд түгээн иргэд, төрийн албан хаагчдад авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх хандлагыг төлөвшүүлнэ.** | | | | | | | | | |
| 116 | 1 | 1.Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, Олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлж, шударга ёсны тогтолцоог төлөвшүүлэх ажил, арга | Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр | Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо | 2021 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 5 удаагийн сургалтаар 208 албан хаагчийн хамруулсан. | Аймгийн нийт төрийн бүх шатны байгууллагуудад авлига, ашиг сонирхлын болон албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил, арга хэмжээг улирал бүр зохион байгуулж, албан тушаалын гэмт | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн нь тогтоогдсон Алтанбулаг, Шаамар сумдын 2 албан тушаалтанд хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцож, дээрх зөрчлийг дахин гаргуулахгүй байх, нийт төрийн албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар зөвлөмж чиглэлийг өгч ажилласан. "Авлигын шалтгаан, хор хөнөөл, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтад дээрх сумдын нийт төрийн албан хаагчдыг хамруулан зохион байгуулж, үр дүнг Авлигатай тэмцэх газарт тайлагнан ажилласан. Төрийн | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах. | | | | | хэргийн гаралтыг өмнөх оны түвшинөөс буурсан байна. | албанд шинээр томилогдсон нийт 48 төрийн албан хаагчийн судалгааг гарган Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, анхан шатны сургалтад цахим хэлбэрээр хамруулан зохион байгуулсан. Авлигатай тэмцэх газартай хамтран “Таны эрх, таны оролцоо-Авлигад үгүй гэж хэлье” өдөрлөгийг 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулж, өдөрлөгт 24 агентлагийн 90 төрийн албан хаагч, 8 багийн 140 иргэн, 6 сургуулийн 287 сурагчдыг, Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагатай хамтран 4 удаагийн сургалтаар 86 төрийн албан хаагчийг тус тус хамруулан ажилласан. | |
| 117 | 2 | 2."Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор “Шударга удирдагч, шударга төрийн албан хаагч” аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулах. | Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр | Аяны удирдамжийг гаргаж, холбогдох алба хаагчдад хүргүүлж хэрэгжилийг хангаж үр дүнг тооцох | 2021 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/292 дугаар аймгийн Засаг даргын захирамжаар “Шударга Удирдагч, Шударга Төрийн албан хаагч” аяныг эхлүүлсэн. | Авлига ашиг сонирхлын зөрчлийн тоо өмнөх оныхоос буурсан байна | “Авлига ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцлийг арилгуулах, ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор “Шударга удирдагч, шударга төрийн албан хаагч” аян зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2021 оны А/292 дугаар захирамжаар аяныг өрнүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан. Аяны хүрээнд сум, байгууллагууд төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйлийг дагаж мөрдөх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төсөв санхүүгийн нээлттэй ил тод байдлыг ханган ажиллах, орон тооны бус Соён гэгээрүүлэх хороо байгуулан төрийн албан хаагчдын харилцаа ур чадварыг нэмэгдүүлэх, зөв хандлагыг төлөвшүүлэх, төрийн ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллах зэрэг ажлыг санаачлан аянд нэгдэн ажиллалаа. Сумдын Засаг дарга нараас аймгийн Засаг даргад “Авлига, ашиг сонирхлын болон санхүү, ёс зүйн зөрчил гаргахгүй ажиллах баталгаа”-г гарган ажилласан. Авлигатай тэмцэх газартай хамтран аяны нээлтийг аймгийн нийт төрийн албан | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хаагчдын дунд зохион байгуулж, Авлигын эсрэг хууль тогтоомжийн сургалтыг 24 агентлаг, 17 сум, 6 тосгоны төрийн албан хаагчдад цахимаар 2 удаа, танхимаар 18 удаа зохион байгуулж, сургалтад 1120 албан хаагч, мөн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Авлигатай тэмцэх газартай хамтран "Авлигын эсрэг хамтдаа" сургалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, нийт 325 албан хаагчийг тус тус хамрууллаа. | |
| **ЗУРГАА.НОГООН ХӨГЖИЛ** | | | | | | | | | |
| **Зорилго: Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | |
| **6.1. Байгалийн баялгийн үр өгөөж** | | | | | | | | | |
| **Зорилт: Байгальд ээлтэй, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 118 | 1 | Ашигт малтмал олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газруудад техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх | Аж ахуй нэгжийн хөрөнгө оруулалт | Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ га-аар | 2021 | 10 аж ахуй нэгж 78.4 га талбайд нөхөн сэргээлт хийсэн . | Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн хэмжээг 50га-аар нэмэгдүүлсэн байна. | 2022 онд 10 аж ахуйн нэгж 112.45 га талбайд техникийн, 89.74 га талбайд биологийн, 257.4 га талбайд дүйцүүлэн хамгаалж, эвдэрч олон жил эзэнгүй орхигдсон талбайд техникийн нөхөн сэргээлт хийж, Баянгол сумын Хараа багийн нутагт Бортолгой хэмээх газарт 45.6 га талбайд зурвас байгуулж, Доргонтод 7000 га орчим талбайд бэлчээрийн менежментийг сайжруулж, Ерөө сумын Хужиртын эх нэртэй булгийг хашиж хамгаалж, 710 ширхэг жимс, жимсгэний мод тарьж, Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 373.3 мянган ширхэг мод, бут тарьж, арчлан ургуулж, өмнөх оныхоос техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн 117.64 га-аар нэмэгдсэн. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг дарга "Оюу толгой" ХХК хамтран ажиллах гэрээ байгуулан Ерөө сумын "Ялбагийн гол" нэртэй газар олон жил эзэнгүй орхигдсон 110 га талбайд "Бугант нандин" ХХК, "Үзэгт дэлгэрэх" ХХК техникийн нөхөн сэргээлтийг хийсэн. | 100% |
| **6.2.Үнэт баялаг ус** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт:Усны нөөцийг хамгаалж, хуримтлал бий болгож, хомсдол бохирдлоос сэргийлнэ.** | | | | | | | | | |
| 119 | 1 | 1. Булаг шандын эхийг хамгаалж, ундарга урсцыг нэмэгдүүлэх | БХНСА ХЗ 20,0 сая төгрөг | Хамгаалагдсан булаг шандын тоо | 2021 | 4 булаг шандын эхийг хашиж хамгаалсан. | Баруунбүрэн, Орхон, Орхонтуул, Сант, Хүдэр сумдын 5 булаг шандын эхийг хамгаалсан байна | Баруунбүрэн сумын "Бүдүүний булаг", Сант сумын "Мухар бүдүүний булаг", Хүдэр сумын "Сөдтэйн булаг", Орхон сумын "Нам ухаагийн булаг", Орхонтуул сумын "Наран хөхий" булаг шандын эхийг хашиж хамгаалсан. | 100% |
| 120 | 2 | 2. "Усны үнэ цэнэ" сэдэвт сургалтыг зохион байгуулах. | БХНСА ХЗ 3,0 сая төгрөг | Зохион байгуулсан эсэх | 2021 | 2018, 2019 онд сургалтууд зохион байгуулагдаж байсан | Сургалтыг зохион байгуулж 150 сурагчдыг хамруулсан байна. | “Дэлхийн усны өдөр”-ийг “Газрын доорх ус-үл харагдах усыг таниулья” уриан доор аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлж, “Усны үнэ цэнэ” сэдэвт сургалт хэлэлцүүлгийг 17 сумын 470 гаруй хүнийг оролцуулан зохион байгуулж, газрын доорх-үл харагдах усыг таниулах бидний нүдэнд үл харагдах далд баялаг болох газрын доорх усыг судлах, үнэ, цэнийг таниулах, бохирдлоос хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах, нөөцийг зохистой ашиглах талаарх мэдлэгийг олгосон. | 100% |
| 121 | 3 | 3.Хөв цөөрөм байгуулах | БХНСА ХЗ 180,0 сая төг | Байгуулагдсан хөв цөөрөмийн тоо | 2021 | Мандал сумын Тэмээтийн хотгор Улаанбилүүтийн голд 2018 онд хөв цөөрөм байгуулсан Дундаж хувь | Судалгааг хийж, хөв цөөрөм байгуулсан байна | Орхонтуул сумын "Замын булаг" нэртэй газарт замын булгийн усыг хуримтлуулах, хөв, цөөрөм барих ажлыг нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, "Сэлэнгэ ундрам" ХХК шалгаран хөв цөөрөм байгуулсан. | 100% |
| **6.3. Хүртээмжтэй ногоон хөгжил** | | | | | | | | | |
| **Зорилт: Байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 122 | 1 | 1.Ойн салбарын ажиллагсдын чуулга, уулзалтыг зохион байгуулах. | БХНСА ХЗ 10,0 сая төг | Нэмэгдүүлсэн ойн талбай/га/ Үр үрсэлгээний тоо хэмжээ | 2021 | Сүүлийн 5 жилд зохион байгуулагдаагүй | Ажиллагсдын мэдлэг, ур чадвар дээшилж, харилцан туршлага солилцох нөхцөл бүрдэнэ. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд “ТАРЬЦ, СУУЛГАЦ НИЙЛҮҮЛЭГЧ АЙМАГ” болох эрхэм зорилтыг дэвшүүлэн “Тэрбум мод-Сэлэнгэ аймагт” зөвлөгөөнийг зохион байгуулж, МЕТГ, БОАЖЯ, сумын болон сум дундын Ойн анги, ойн мэргэжлийн байгууллага, мод үржүүлгийн газруудын нийт 400 гаруй төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. Алтанбулаг, Ерөө, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Түшиг, Мандал, Цагааннуур зэрэг сумдын “Тэрбум мод зөвлөгөөн”-ийг 3000 гаруй аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулан модны тарьц, суулгац болон үр, бордооны үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан. | |
| 123 | 2 | 2. Мод үржүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийг саналыг дэмжиж “Мод үржүүлэг-Ногоон байгууламж” аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж үр дүнг тооцох. | Орон нутгийн төсөв, БХНСА ХЗ | Ойжуулалт хийсэн талбайн хэмжээ | 2021 | Мод үржүүлгийн 38 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа нь улс аймгийн хэмжээнд хэрэглэгдэх модны үр тарьц суулгацын нөөц хангалтгүй байна. | Үрийн нөөцийг нэмэгдүүлж, иргэд аж ахуйн нэгжийн санал санаачлагад дэмжлэг үзүүлж, аяны үр дүнг тооцсон байна. | Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах, нийлүүлэгч аймаг болох зорилтын хүрээнд "Мод үржүүлэг ногоон байгууламж аян"-ыг аймгийн Засаг даргын 01/1528 дугаар албан бичгээр аймгийн хэмжээнд зохион байгуулж, мод, тарьц, суулгац ургуулах, хэлбэржүүлэх, цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хийгдсэн ажлын тайлан үндэслэн шалгаруулахаар ажиллаж байна. Мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих зорилгоор "Хог ургамлыг устгах, бордоо ашиглах нь сургалт"-ыг зохион байгуулж, 50 аж ахуйн нэгж, иргэдийг хамруулж, Налайх дүүрэг, Булган, Орхон, Хөвсгөл, Хэнтий аймгууд болон ОХУ-ын мод үржүүлгийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн танилцах уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. | 90% |
| 124 | 2 | 2. Мандал, Ерөө сумдад ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэх | БХНСА ХЗ 139,0 сая төгрөг | Бургасжуулсан талбайн хэмжээ | 2021 | 200га талбайд ойжуулалтын ажлыг хийсэн байна. | Үрийн нөөцийг нэмэгдүүлж, иргэд аж ахуйн нэгжийн санал санаачлагад дэмжлэг үзүүлж, аяны үр тооцсон байна. | Мандал сумын "Хар модот" нэртэй газарт 200 га талбайд "Ойн хүрэм" ХХК ойжуулалтын ажлыг хийсэн. | 50% |
| 125 | 3 | 3. Мандал сумын нутаг Хараа голын эрэг орчмыг бургасжуулах | БХНСА ХЗ 60,0 сая төгрөг | Ойжуулалтын хэмжээ /га/ | 2021 | 200 га талбайд ойжуулалтын ажлыг хийсэн. | 10 га талбайг бургасжуулсан байна. | Голын эрэг орчмыг бургасжуулах ажлыг Мандал суманд 10 га талбайд "Тэнгэрлэг ой" ХХК 6000 ширхэг бургас тарьж, хашаажуулсан. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 126 | 4 | 4. Хүдэр, Ерөө, Мандал сумдад жодоо, хуш, гацуур зэрэг ховор зүйлийн модоор ойжуулалтын ажлыг хийх | БХНСА ХЗ 6.0 сая төг | Ойн зурвас байгуулсан хэмжээ /га/ | 2021 | хүдэр суманд 1.5 га, Ерөө суманд 5 га талбайг ойжуулсан. | Ойжуулалт хийсэн талбайн хэмжээ 5 га-гаар нэмэгдсэн байна. | Ерөө сумын 189 дүгээр хэсэглэлийн 14, 18 дугаар ялгарал буюу Толгойтын голд 5 га талбайд Ерөө бүсийн сум дундын Ойн ангитай гэрээ байгуулан хуш модны 6100 ширхэг тарьцаар ойжуулалтын ажлыг хийсэн. | 100% |
| 127 | 5 | 5. Элсний нүүдэлд өртсөн талбайд ойн зурвас байгуулах. | БХНСА ХЗ 220,0 сая төг | Тэмцэл хийсэн талбайн хэмжээ /га/ | 2021 | Алтанбулаг, Жавхлант сумдын 20 га талбайд ойн зурвас байгуулсан. | 20 га талбайд ойн зурвас байгуулж цөлжилт, элсний нүүлт саарсан байна. | Цөлжилт, элсний нүүлтэд өртсөн талбайд хамгаалалтын зурвас байгуулах ажлыг Алтанбулаг, Орхон, Сайхан, Сүхбаатар сумдад тус бүр 5 га талбайд "Тэнгэрлэг ой", "АгроФорест" ХХК, "Ойн хүрэм" ХХК-иуд хийж, гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. | 90% |
| 128 | 6 | 6. Ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажлыг ойн сан, гол хөвөөлсөн бургасанд хийх. | Улсын төсөв, БХНСА ХЗ 200.0 сая төг | Зурвас байгуулж арчилгаа хийсэн талбайн хэмжээ /га/ | 2021 | 6741.543 га талбайд ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажлыг гүйцэтгэсэн. | 5000 га-д хийсэн байна | Ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажлыг Баруунбүрэн, Орхон, Орхонтуул, Ерөө, Сант, Цагааннуур сумдын 5000 га талбайд “Мөнхжаргалант ой” ХХК, “Залуу төгөл” ХХК, “Мөнх ногоон жодоо” ХХК, “Ньюгрийн форест” ХХК, “Мөнх ногоон ой”ХХК-иуд хөнөөлт шавжийн тэмцлийн ажлыг хийсэн. | 100% |
| 129 | 7 | 7.Түймрээс хамгаалах шороон зурвасын арчилгаа хийх | БХНСА ХЗ 10.0 сая төг | Арга хэмжээ авч ажилласан сумдын тоо | 2021 | 118 км талбайд шороон зурвасны арчилгааны ажил хийсэн. | 118 км талбайд арчилгааны ажил хийсэн байна. | Алтанбулаг, Түшиг сумдын хил дагуух 118 км газарт түймрээс хамгаалах шороон зурвасын ажлыг хилийн цэргийн 0243-р ангитай хамтран хийсэн. | 100% |
| 130 | 8 | 8. Зэрлэг амьтдыг хүнс, тэжээлийн хомсдолд орохоос урьдчилан сэргийлж Биотехникийн арга хэмжээ авч ажиллах. | БХНСА ХЗ 20.0 сая төг | Тарьсан модны тоо | 2021 | Биотехникийн арга хэмжээг 9 суманд авч ажилласан. | Биотехникийн арга хэмжээг 10 суманд хэрэгжүүлсэн байна. | Алтанбулаг сумын Ивцэг, Хазай, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг сумдын “Хоёр даваа”, “Шүрэн Баруун гол”, “Сангилтай”, “Номт өндөр”, “Ар Шүрэн”, “Хажингийн нуруу” агнуурын бүс нутагт Бэлчирийн бүсийн сум дундын Ойн анги, Мандал, Баянгол сумдын “Ар”, “Өвөр Гахайт”, Түнхэл, Баян агнуурын бүс нутагт Хараа бүсийн сум дундын Ойн анги, Жавхлант, Ерөө сумдын Цагаан даваа, Бугант, Бүхлэй, Бэрлэг-Ялбаг агнуурын бүс нутагт Ерөөгийн бүсийн сум дундын Ойн анги, Хүдэр сумын Тарвагатай, Малгайт-Шоргоолж, Сэвсүүл, Төхөмийн хөндий агнуурын бүс нутагт Хүдэр сумын Ойн анги, Баруунбүрэн, Сант, Хушаат сумдын Сэндэн, Ар | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Бургалтай, Тэлд, Ар тойлбо агнуурын бүс нутагт Түвшинбүрэн ойн нөхөрлөлийн холбоо тус тус биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлж, нэн ховор, ховор амьтдад зориулан 900 кг давс, 900 боодол өвс тавьсан. Орхонтуул сумын 2-р багийн нутаг "Халтар ишиг", “Хөх ишиг” нэртэй газруудад аргальд зориулан биотехникийн арга хэмжээнд 200 кг хорголжин тэжээл, ундаалдаг газарт нь усыг задгайлах мөн хөдөлгөөн мэдэрдэг камер байршуулсан. | |
| 131 | 9 | 9.“Тэрбум мод тарих хөдөлгөөн”-ийг эрчимжүүлж ногоон байгууламж, ойжуулалтын хэмжээг нэмэгдүүлэх. | Улсын болон орон нутгийн төсөв | Ногоон байгууламжийн тоо | 2021 | Аймгийн хэмжээнд 7150 ширхэг мод суулгацыг тарьсан. | Тарих модны хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэн байна. | “Тэрбум мод” хөдөлгөөнийг орон нутаг зохион байгуулах” аймгийн Засаг даргын 2022 оны “Бүх нийтээр мод тарих арга хэмжээг зохион байгуулах” ажлыг 17 сум, 6 тосгонд хүргүүлж, мод тарьж ургуулах чиглэл, зөвлөмж өгч, аймгийн хэмжээнд 1745 өрх 23,2 мянган ширхэг модыг шинээр тарьж, 24 га талбайд ногоон байгууламж, 1087.8 га талбайд ойжуулалт, 30 га талбайд ногоон зурвас, 5 га талбайд цэцэрлэгжүүлэлтийг ажлыг хийж, 467 аж ахуйн нэгж, 7.4 мянган иргэд 778.9 мянган ширхэг модыг тарьж ургуулан 859,5 сая төгрөгийн хөрөнгийг гарган зохион байгуулж, эх байгалиа хайрлан хамгаалж, мод бүх нийтийн үйлс болгосон. Ерөө, Зүүнбүрэн, Орхон, Орхонтуул, Түшиг, Цагааннуур зэрэг 6 суманд шинээр бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулж, 5604 ширхэг мод, бут сөөг тарьж, Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаа “Тэнгэрлэг ой” ХХК Алтанбулаг суманд 1 га талбайд “Ногоон төгөл”-ийг шинээр байгуулж, 93.0 сая төгрөг зарцуулж, ногоон байгууламжийн 2665 м2 талбайг зүлэгжүүлэн, 291 цэцгийн мандал байгуулсан. “Мод тарьж ургуулах арга аргачлал, зөвлөмж”, “Мод тарьж ургуулах, арчлах, услах арготехникийн хуанли”-г хэвлүүлэхэд шаардлагатай хөрөнгийг аймгийн Засаг | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас 6.5 сая төгрөгийг зарцуулсан. | |
| 132 | 10 | 10. Агаар, ус, хөрсний бохирдлыг багасгаж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, ээлтэй орчинг бүрдүүлэх. | БХНСА ХЗ 94,0 сая төгрөг | Батлагдсан орон тоо | 2021 | 2019 онд Сүхбаатар сумын 5 багт 2.7 га талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулсан . | Алтанбулаг суманд 2 га талбайд байгуулна. | Төв суурин газрын ногоон байгууламжийн 2665 м2 талбайг зүлэгжүүлэн, 291 цэцгийн мандал, Алтанбулаг суманд 1 га талбайд "Тэнгэрлэг ой" ХХК шинээр ногоон төгөл байгуулсан. | 50% |
| 133 | 11 | 11. Ойн ангиудын мэргэжлийн боловсон хүчнээр хангах, мэргэшүүлэх, чадваржуулах, үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх. | БХНСА ХЗ | | 2021 | Сумдын ойн ангиудын бүтэц орон тоо нэмэгдсэн байна | Сумдын ойн ангиудыг мэргэжлийн боловсон хүчнээр хангагдаж мэдлэг ур чадвар дээшилсэн байна | Ойн ангиудын ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор "Цахимжуулалтын тухай е-цахим платформ", "Ойн хөнөөлт шавжийг таних, тэмцлийн ажил явуулах тухай", "Ойд I,II насны арчилгааны огтлолт явуулахад анхаарах зүйлс зэрэг сургалт", “Эко бордоо хэрэглэх нь сургалт”, “Хог ургамал түүх сургалт”-ыг зохион байгуулж, 17 сумын 3 ойн анги,15 нөхөрлөл, 25 мод үржүүлгийн газрын албан хаагчдын мэдлэг, ур чадвар дээшлүүлж, чадавхжуулсан. “STREAM” төсөстэй хамтран "Мод тарьж ургуулах “1000 сургагч багш бэлтгэх сургалт-нд сум тус бүрээс 3 хүн хамрагдаж 51 сургагч багш бэлтгэж, иргэд мод тарьж ургуулах аргыг зааж, түгээн дэлгэрүүлж байна. Сурагчдад мод тарих ач холбогдлын талаар сургалт, сурталчилгааг явуулж, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг сумдын 26 хүүхдэд “Ногоон паспорт” олгосон. | 100% |
| **ДОЛОО.АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ** | | | | | | | | | |
| **Зорилго: Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, орон нутгийн аюулгүй байдлыг хангана** | | | | | | | | | |
| **7.1.Зэвсэгт хүчин** | | | | | | | | | |
| **Зорилго: Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг ард иргэдэд сурталчилсанаар иргэдийн иргэний цэргийн үүргээ биелүүлэх мэдлэг, хандлагыг** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| дээшлүүлнэ. | | | | | | | | | |
| 134 | 1 | 1. Аймгийн “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-ний дагуу томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, бэлтгэлийг хангах сургалтыг зохион байгуулах | Орон нутгийн төсвөөс 4.2 сая төгрөг | Сургалтад хамруулахаар сонгогдсон томилгоот бие бүрэлдэхүүний хамралтын хувь | 2021 | "Ковид-19" цар тахлаас шалтгаалан сургалт явагдаагүй. | Аймгийн Орон нутгийн хамгаалалтын нийт томилгоот бүрэлдэхүүний 5 хүртэл хувь нь сургалтад хамрагдсан байна. | Батлан хамгаалахын сайдын 2022 оны 1а/2525 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/290 дүгээр захирамж, Цэргийн штабын 2022 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Төвийн бүсийн аймгуудын сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар Булган аймагт “Цэргийн бэлтгэл” сургалтад 2022 оны 08 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд хамрагдсан. Булган сумын Батлан хамгаалах товчоог дэлгэн томилгоот бүрэлдэхүүний хээрийн нөхцөлд байрлах байр, техник болон хөтлөгдөх баримт бичгийг дэлгэн үзүүлэх сургуулийг зохион байгуулсан. Мөн энэ үеэр Батлан хамгаалах сайдын 2020 оны А/121 дүгээр тушаалыг үндэслэн буудлага хийх үеийн аюулгүйн ажиллагааны зааварчилгааг танилцуулж хүн нэг бүрээр гарын үсэг зуруулан баталгаажуулж аюулгүй байдлыг хангуулан “Буудлагын анхны дасгал”-ыг Булган сумын Өндөр хөтөлийн районд урьдчилан бэлтгэсэн буудлагын талбайд буудлага явуулсан. Энэхүү сургалтаар төрийн албан хаагчдад сумдад Батлан хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах мэдлэг, дадлагыг дээшлүүлсэн. | 100% |
| 135 | 2 | 2. Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Эрүүлжсэн цэргийн насны залуучуудын тоо болон суурь түвшний бууралтын хувь | 2021 | Хугацаат цэргийн албаны татлагын эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан цэргийн насны залуучуудын 76 хувь нь ямар нэгэн өвчин эмгэгтэй байна. | Цэргийн насны залуучуудын өвчлөлийг 10 хүртэл хувиар бууруулсан байна. | Хугацаат цэргийн албаны татлагын эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан 7461 иргэний 4938 нь буюу 66,18 хувь нь эрүүл мэндийн шалтгаанаар хасагдсан бол тэдгээрийн 19,6 хувь нь дотор, 18,3 хувь нь мэс засал, 15,3 хувь нь чих-хамар хоолой, 15,4 хувь нь арьс-харшалын өвчнүүдээр тус тус хасагдсан. Тус аймгаас ээлжит цэрэг татлагад хамрагдсан нийт цэргийн насны залуучуудын назлогийн судалгаанд үнэлгээ дүгнэлт хийж Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг болон сумдын Эрүүл мэндийн төвүүдтэй хамтран ажиллаж өвчнийг 5 хүртэл хувиар бууруулсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Хугацаат цэргийн албаны ээлжит цэрэг татлагыг 2022 онд 2 удаа бүсчлэн зохион байгуулсан. Үзлэгт хамрагдсан татагдагчдаас эрүүл мэндээр тэнцсэн иргэдийн 28.9 хувийг хугацаат цэргийн албанд тэнцүүлэн татаж Зэвсэгт хүчин болон Хил хамгаалах байгууллагад хүлээлгэн өгч хяналтын тоог биелүүлсэн. | |
| 136 | 3 | 3. "Эрүүл иргэн-Энхийн манаа" сэдвийн хүрээнд идэрчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулна. | Орон нутгийн төсвөөс | Сургалтад хамрагдсан идэрчүүдийн тоо | 2021 | Сургалт зохион байгуулагдаж байгаагүй. | Аймгийн Ерөнхий боловсролын 35 сургуулийн ахлах ангийн сурагчдыг 90 хүртэл хувийг хамруулсан байна. | "Цэргийн насны залуучууд болон идэрчүүдийн эрүүл мэндийг хамгаалах, аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл иргэн байхын ач холбогдлыг таниулах, эх оронч үндэсний үзэл төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ" гэсэн зорилгын хүрээнд бүх суманд "Эрүүл иргэн энхийн манаа" сургалтыг 12 дугаар сарын 01-15-ны өдрүүдэд зохион байгуулсан. Энэхүү сургалтад нэгдсэн дүнгээр ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 850 гаруй сурагчид, цэргийн насны 470 гаруй залуучууд нийт 1320 иргэд хамрагдсан. Тэдэнд аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас баталсан хөтөлбөрийн хүрээнд "Монгол хүн байхын учир", "Эрүүл иргэн байхын ач тус" нөлөөллийн лекц, "Идэвхтэй хөдөлгөөн – Эрүүл мэнд" сэдвийн хүрээнд сургалтад хамрагдагсдад цэргийн 1 болон 2 дугаар 16 тоот дасгалыг зааж, сургасан бол иргэн – цэргийн харилцааг бэхжүүлэх, Монгол Улсын Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчнийг сурталчлах ажлын хүрээнд "Эх оронч үзэл үндэсний бахархал – Монгол цэрэг – Дэлхийн цэрэг" зэрэг лекцийг сумдын Засаг даргын Тамгын газраас томилогдсон бүрэлдэхүүн уншиж харилцан ярилцлаа. Мөн энэхүү арга хэмжээний үеэр "Өнө мөнх дурсагдах алдар – Бидний бахархал" сэдвийн хүрээнд сумаас төрөн гарсан партизан цэргүүд, БНМАУ-ын Баатар, хөдөлмөрийн баатрууд болон гавьяат | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | цолтнууд, алдартнуудын ажил, амьдрал, намтарын талаар сурталчлах ярилцлагыг тухайн сумандаа нэр хүндтэй ахмад настнуудтай хийсэн. Энэхүү ярилцлагад аймгийн хэмжээнд 31 ахмад настан оролцсон. | |
| 137 | 4 | 4. Цэргийн штабын “Сургалтын төв”-ийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх. | Орон нутгийн төсөв | Тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн хувь | 2021 | Сургалтын төвийн газрын хашааны суурь ухаж тэмдэглэгээ хийсэн. | Сургалтын төвийн бүтээн байгуулалтын ажлын 25 хувийг гүйцэтгэнэ. | Сургалтын төвийн хашааны суурийн ажлын нүхийг ухаж цутгалт хийхэд бэлэн болгосон. 2023 оны төсөвт 120 сая төгрөгийг тусгуулан ажиллаж байна. | 100% |
| 138 | 5 | 5.Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын нэрэмжит цэрэг спортын цогцолбор “Дөл” тэмцээнийг зохион байгуулах | Орон нутгийн төсвөөс 3.68 сая төгрөг | Зохион байгуулагдсан арга хэмжээнд хамрагдсан хүүхэд, залуучуудын тоо | 2021 | Ковид-19 цар тахлаас шалтгаалан тэмцээн, уралдаан болон бусад арга хэмжээ явагдаагүй. | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын 23 хувь буюу 705-аас доошгүй нь хамрагдсан байна. | Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны А/123 дугаар захирамжаар батлагдсан Сэлэнгэ аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл-2022” цогцолбор тэмцээнийг аймаг, бүс, сум гэсэн 3 үе шаттайгаар зохион байгуулсан. Тэмцээний гуравдугаар шатанд Ерөнхий боловсролын 12 сургуулийн 140 гаруй сурагчид, 20 орчим багш нар оролцсон.”Тэргүүн” байранд Мандал сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн Б.Тэмүүжин захирагчтай “Сүлд” тасаг, “Дэд” байранд Мандал сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн Б.Билгүүндалай захирагчтай “Шонхор” тасаг, “Гутгаар” байранд Мандал сумын Түнхэл тосгоны Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн Б.Тэмүүжин захирагчтай “Альфа” тасаг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж байгаа Батлан хамгаалахын сайдын нэрэмжит улсын аварга шалгаруулах “Дөл-2022” цэрэг-спортын цогцолбор тэмцээнд амжилттай оролцсон. Цогцолбор тэмцээний нэг төрөл болох ханын сонины уралдаанд “Тэргүүн байр”-т Сэлэнгэ аймгийн “Сүлд” тасгийн сурагч А.Мөнхтөр, Мишээл нар тэргүүлсэн. Сэлэнгэ аймгийн “Сүлд” тасгийн захирагч Б.Тэмүүжин ҮБХИС-д суралцах урилгаар шагнуулсан ба | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | соёлтой цэвэчр нямбай тасгаар Сүлд тасгийн бүрэлдэхүүн шалгарсан. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор баталсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”, хүрээнд Монгол Улсын Ерөнхий Командлагчийн санаачлагаар “Бидний бахархал” төслийн нээлтийн арга хэмжээг Ардын хувьсгалын өлгий нутаг Сэлэнгэ аймагт “Монгол хурандаа” нийгэмлэгээс анх удаагаа 2022 оны 12 дугаар сарын 05-09-ний өдрүүдэд зохион байгуулсан.Тус арга хэмжээнд Төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллагуудын 500 гаруй алба хаагчид, ерөнхий боловсролын сургуулийн 1800 гаруй оюутан, сурагчид хамрагдсан. Энэхүү арга хэмжээнд хүүхэд, залуучуудад цэрэг эх орон үндэсний үзэл төлөвших, эх орноо хайрлан хамгаалахын ач холбогдыг ойлгуулсан сургалт болсон. | |
| **7.2. Дархан хил** | | | | | | | | | |
| **Зорилт. Улсын хил хамгаалалтанд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, хил хамгаалах албаны бэлэн байдлыг дээшлүүлнэ.** | | | | | | | | | |
| 139 | 1 | 1. Ойн 100,2 км шороон зурвасыг сэргээх, 20 км ойн зурвасыг сэргээж, өргөсгөх | Улсын болон орон нутгийн төсөв | Ойн зурвасыг сэргээх болон шинээр байгуулах зурвасын хэмжээ | 2021 | Номт дахь заставын хариуцсан хэсэгт 18 км ойн зурвасыг сэргээсэн | Хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлж, Хил дамнасан түймрээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдсэн байна. | Алтанбулаг, Түшиг сумдын хил дагуух 118 км газарт түймрээс хамгаалах шороон зурвасын ажлыг хилийн цэргийн 0243 дугаар ангитай хамтран хийж, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлж, хил дамнасан түймрээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдүүлсэн. | 50% |
| 140 | 2 | 2. Алслагдсан хилийн салбарт ажиллаж, амьдарч буй албан хаагч тэдний гэр бүл, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалж, боловсрол, хөгжлийг дэмжих | Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулал | Хамрагдсан албан хаагч, гэр бүлийн тоо | 2021 | Хилийн заставт алба хааж буй 3 алба хаагчдын гэр бүл, хүүхдийн эрүүл мэндийн хөгжлийг дэмжих зорилгоор улирал бүр 420,0 мянган төгрөгийн | Хилчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэж, дэмжлэг үзүүлсэн байна. | Хилийн ангийн алба хаагчдын ар гэрийн 7 иргэнийг ажлын байраар хангаж, албан хаагчдын гэр бүлийн 15 гишүүний эрүүл мэнд, нийгмийн даатгалыг төлж нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн. Мөн хилийн салбарт ажиллаж буй 10 алба хаагчдад гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 0.7 га газрыг олгож, төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт 192 алба | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | т, төсөл хөтөлбөр | | | дэмжлэгийг үзүүлэн ажилласан. | | хаагч, 16 ахмад хилчин, 43 алба хаагчдын гэр бүлийн гишүүдийг хамруулж, нийгмийн баталгааг хангaн дэмжлэг үзүүлэн ажилласан. | |
| **7.3.Хүн, нийгмийн амар, тайван байдал** | | | | | | | | | |
| **Зорилт: Улсын батлан хамгаалах чадавхийг бэхжүүлж, хүний эх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн амар, тайван аюулгүй байдлыг хангана.** | | | | | | | | | |
| 141 | 1 | 1. Гэмт хэрэг, зөрчил болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажилд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх. | Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр | Иргэдийн оролцооны хувь | 2021 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөлтэй хамтран болзолт уралдааныг зарлан ажиллаж байна. | Камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурсан байна. | Сүхбаатар, Алтанбулаг сумдын гудамж, зам, талбайг теле хяналтын системийг өргөтгөх төслийн хүрээнд Сүхбаатар, Алтанбулаг сумыг теле хяналтын нэгдсэн системд холбох, тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуй нэгжийг уг системд холбох ажлыг үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөсөн. Төслийн хүрээнд орон нутгийн хөрөнгөөр 40 цэгт 100 камер байршуулахад 244,000,000 /хоёр зуун дөчин дөрвөн сая/ төгрөгийн зардлын төсвийг гаргаж шийдвэрлүүлсэн. Сумдын цагдаагийн хэсгүүдийг теле хяналтын камерийн системд холбох ажлын хүрээнд Орхон, Орхонтуул, Баруунбүрэн сумдын Цагдаагийн хэсгийн байруудыг камержуулахад нийт 35,580,000 /гучин таван сая таван зуун наян мянга/ төгрөгийг орон нутгийн хөрөнгөөр шийдвэрлэсэн. | 100% |
| 142 | 2 | 2. Тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох олон талт ажил, арга хэмжээ зохион байгуулах. | Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр | Гэмт хэрэг зөрчлийн тоо | 2021 | Хүний нэр төрд халдах, Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 71, Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах-8 | Гэмт хэрэг, зөрчлийн улмаас учирсан хохирлыг барагдуулах боломж, нөхцөл бүрдсэн байна | 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 775 гэмт хэрэг, 36150 зөрчил бүртгэгдэж шалгагдсан. Эдгээр гэмт хэрэг, зөрчлийн улмаас байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 5.663.960.000 төгрөгний хохирлоос 2.377.170.000 төгрөгний хохирлын нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэх нөхцөл боломжийг хангах зорилгоор 263.900.000 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэн ажиллалаа. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 143 | 3 | 3. Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, таслан зогсоооход төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, өрх, гэр бүлийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх. | Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр | Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо | 2021 | Хүүхдийн эрхийн Хууль зүйн хороогоор дамжуулан 18 хүүхдэд үйлчилгээ үзүүлж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,9 хувиар буурсан байна. | гэмт хэргийн гаралтыг 10 хувиар бууруулсан байна. | Аймгийн хэмжээнд 2022 онд мал хулгайлах гэмт хэрэг 55 бүртгэгдсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 22 хэрэг буюу 66.7 хувиар өссөн. Бүртгэгдсэн 48 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 19 гомдол мэдээллийг татгалзсан. “Мал мах-2022” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн Прокурорын газартай хамтран энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, чиглэлээр зөвлөгөөнийг 2022 онд 14 сум, 4 тосгонд зохион байгуулж, 2600 малчдыг хамруулж, мал хулгайлах болон гарал үүслийн бичиггүй мал, мах тээвэрлэх, худалдан борлуулах үйлдлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор малын хулгайгаас урьдчилан сэргийлэх тухай 15 зурагт хуудас, видео шторкыг иргэдийн хандалт ихтэй 25 групп, цахим хуудсаар дамжуулан 7600 иргэнд хүргэн ажилласан. | 100% |
| **7.4.Хууль сахиулах салбарын хөгжил** | | | | | | | | | |
| **Зорилт: Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинэ түвшинд гаргана.** | | | | | | | | | |
| 144 | 1 | 1. Гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг цэгүүдэд дэвшилтэт технологи бүхий камер суурилуулж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх. | Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр | Камержуулалтын тоо | 2021 | 2021 оны орон нутгийн төсвийн сангийн 47,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар, Шаамар сумын гурвалжингийн пост, 4 зам хяналтын пост зэрэг 4 гол цэгт тус тус байршуулсан. | Камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурсан байна. | Сүхбаатар, Алтанбулаг сумдын гудамж, зам, талбайг теле хяналтын системийг өргөтгөх төслийн хүрээнд Сүхбаатар, Алтанбулаг сумыг теле хяналтын нэгдсэн системд холбох, тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуй нэгжийг уг системд холбох ажлыг үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөсөн. Төслийн хүрээнд орон нутгийн хөрөнгөөр 40 цэгт 100 камер байршуулахад 244,000,000 /хоёр зуун дөчин дөрвөн сая/ төгрөгийн зардлын төсвийг гаргаж шийдвэрлүүлсэн. Сумдын цагдаагийн хэсгүүдийг теле хяналтын камерийн системд холбох ажлын хүрээнд Орхон, Орхонтуул, Баруунбүрэн сумдын Цагдаагийн хэсгийн байруудыг камержуулахад нийт 35,580,000 /гучин таван сая таван зуун наян мянга/ төгрөгийг орон нутгийн хөрөнгөөр шийдвэрлэсэн. | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 145 | 2 | 2. Гэмт хэрэг, зөрчлийн улмаас учирсан хохирлыг барагдуулах боломж, нөхцөлийг дээшлүүлэхэд хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх. | Улсын болон орон нутгийн төсөв | Хохирол нөхөн төлүүлэлтийн хэмжээ | 2021 | Гэмт хэрэг зөрчлийн улмаас иргэн, байгууллага аж ахуйн нэгжид 2724,2 сая төгрөгийн хохирол учирсан. Тус хохирлын 616,3 сая буюу 24,3 хувийг мөрдөн шалгах ажиллагааны шатанд нөхөн төлүүлэн ажилласан. | Гэмт хэрэг, зөрчлийн улмаас учирсан хохирлыг барагдуулах боломж, нөхцөл бүрдсэн байна | 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 775 гэмт хэрэг, 36150 зөрчил бүртгэгдэж шалгагдсан. Эдгээр гэмт хэрэг, зөрчлийн улмаас байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 5.663.960.000 төгрөгний хохирлоос 2.377.170.000 төгрөгний хохирлын нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэх нөхцөл боломжийг хангах зорилгоор 263.900.000 төгрөгийн эд хөрөнгийг битүүмжлэн ажиллалаа. | 100% |
